

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

№	Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1.Иргэдийн хяналт оролцоог дээшлүүлнэ.								
1.	1.	Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн сан технологийг ашиглан олон нийтэд нээлттэй, ил тод болгон, шилэн ажиллагааг үргэлжлүүлэх	-	Шилэн ажиллагааны мэдээллийн гүйцэтгэл	60	80	Монгол улсын Засгийн газрын 2024 оны 31 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн /www.shilen.gov.mn/-нд байгууллагын нээлттэй мэдээллийг байршуулж ажилласан. Тайлант хугацаанд 46 байгууллага шинээр бүртгэн нийт 156 байгууллагад системийн эрх нээж, shilen.gov.mn цахим хуудсанд нээлттэй мэдээллээ байршуулах боломжийг бүрдүүлсэн.	90%
2.	2.	Төрийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэдийн оролцоо, хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулах	-	Цахим хуудастай төрийн байгууллагын тоо	40	45	Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэдийн хяналт тавих боломжийг бүрдүүлж төрийн болон төрийн өмчит байгууллагуудыг цахим хуудастай болгох ажлыг хийж гүйцэтгэн тайлант хугацаанд 112 байгууллагыг төрийн мэдээллийн нэгдсэн www.gov.mn цахим хуудсанд бүртгэсэн нь нийт 156 байгууллага албан ёсны цахим хуудастай болсон. Мөн иргэдийн мэдээ мэдээлэл өгөх, санал, хүсэлт гаргах боломжийг нэмэгдүүлэн 7723-1111 аймгийн төрийн үйлчилгээний нэгдсэн лавлах утсыг ажиллуулж 510 иргэн мэдээ мэдээлэл авсан байна.	90%

3.	3.	Иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх	-	Иргэдээс ирүүлсэн санал гомдлын тоо/шийдвэрлэлтийн хувь	1750/100	1760/100	<p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг 7723-1111 тусгай дугаар, dornogovi.gov.mn цахим хаяг, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан мөн биечлэн гэсэн 4 төрлөөр хүлээн авч байна. 05 дугаар сарын байдлаар аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж нийт 309 өргөдөл, гомдол ирсэн нь өмнө оны мөн үе (196)-тэй харьцуулахад 57 хувиар өссөн байна. Өргөдөл, гомдлын өсөлтийн шалтгаан нь түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлтүүд байна. 1.Бичгээр буюу биечлэн - 184, 2.7052-1111 тусгай дугаараар – 16, 3.Dornogovi.gov.mn цахим хуудсаар дамжуулан – 3, 4.Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан – 106 ирсэн байна.</p> <p>Хүлээж авсан нийт 309 өргөдөл, гомдлын 225 буюу 72.8 хувийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн хариу өгсөн бол 84 буюу 27.8 хувь судлагдах шатандаа байна. Шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үе (89.2)-тэй харьцуулахад 16.4 хувиар буурсан байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилан үзвэл хүсэлт-198, гомдол-108, санал-3 байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүсэлт 55 хувиар, гомдол 35.1 хувиар өссөн, санал 62.5 хувиар буурсан байнаТөрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх, төрийн бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/41-р тушаалаар аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт 1-р улиралд иргэдээс хандаж ирсэн өргөдөл, гомдолд хяналт-шалгалт хийсэн. Хяналт-шалгалтын үр дүнд албан хаагчдад өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлсэн бол хяналт тавих, хуулийн дагуу үндэслэл бүхий хариу өгөх зэрэг зөвлөмжүүдийг өгсөн.</p>	70%
----	----	---	---	---	----------	----------	--	-----

2. Хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр

4.	1	Төрийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэх, чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх	-	Ажлын гүйцэтгэл	100	100	Засгийн газрын “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” 2025 оны 37 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулж Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийг байгуулж, шинээр 16 албан тушаал боловсруулан. Мөн сумдад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 4-р улиралд дахин шалгах ажлыг зохион байгуулна.	70%
5.	2	Дорноговь аймгийн “Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөр” “Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад анх удаа орон сууц худалдан авах, барихад нь зориулж дэмжлэг үзүүлэх журам”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	-	Нийгмийн баталгаагаар хангасан төрийн албан хаагчдын тоо	159	220	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09/01 дүгээр тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөр"-ийг 2023-2026 онд хэрэгжүүлэхээр баталсан. Мөн төрийн албан хаагчдыг түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг эрчимтэй зохион байгуулж нийт 100 гаруй төрийн албан хаагч түрээсийн орон сууцанд хамрагдаад байна. 2025 онд 7 албан хаагчид сургалтын дэмжлэгт 138 сая төгрөг, 13 албан хаагчдад 11 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг олгосон.	100 %
6.	3	Төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлж, цогц чадамжтай хүний нөөцийг бүрдүүлж, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэх	-	Цахимаар чадавхжуулсан төрийн албан хаагчийн тоо Танхимаар чадавхжуулсан төрийн албан хаагчийн тоо	4500/387	5000/500	Удирдлагын академийн ахлах түшмэлийн сургалтад 8 албан хаагч, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 12 албан хаагч, анх томилогдсон 14 албан хаагчийг улсын төсвийн хөрөнгөөр сургалтад хамруулсан. Хувийн зардлаар 5 албан хаагчийг сургаж, мэргэшсэн. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтад аймгийн хэмжээнд нийт 540 төрийн албан хаагчийг хамруулсан. Хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байранд нь албан хаагчдыг чадавхжуулахаар Улаанбаатар хот, аймаг, сумдад зохион байгуулагдсан "Сэтгэлгээний өөрчлөлт" сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад 2, Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад 1, "Төрийн албаны манлайлал"	70%

							говийн бүсийн нэгдсэн зөвлөгөөнд 120 албан хаагч, БНХАУ-д цахим худалдаа, цахим системийн талаар туршлага судлах сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан. Тайлант онд төрийн албан хаагчийг сургаж дадлагажуулах, чадавхжуулах танхимын 16 сургалтад 523 төрийн албан хаагчийг хамруулсан. Нийт аймгийн хэмжээнд 1063 албан хаагчийг танхим болон цахим хэлбэрээр чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтад хамруулсан.	
7.	4	Төрийн байгууллага, албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх барилга, ажлын байрны асуудал болон шаардлагатай тоног төхөөрөмж, эд хөрөнгийг үе шаттай шийдвэрлэх	182.0	Ажиллах нөхцөлийг сайжруулсан албан хаагчдын тоо	300	500	Төрийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, орчин бүрдүүлэхээр орон нутгийн 350 сая төгрөгийн төсөвт өртгөөр 14 сум, агентлаг байгууллагад техник хэрэгсэл, тавилга хэрэгжилтийг худалдан авах ажлыг зохион байгуулж 180 албан хаагчийн ажиллах орчин сайжруулсан.	90%
8.	5	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллах	20.0 УТ ОНТ	ТББ-аар гүйцэтгүүлсэн ажлын тоо	7	9	Тайлант хугацаанд төрийн үйлчилгээний КИОСК төхөөрөмжийг 2 суманд ажиллуулж нэг дороос төрийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлснээр 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээ авах боломж нээгдсэн. Мөн "ХурДан" төвөөр дамжуулан тайлант хугацаанд 2815 тоон гарын үсэг, давхардсан тоогоор нийт 8250 иргэнд төрийн үйлчилгээг тус тус үзүүлсэн. Үүнээс цахимаар авч буй үйлчилгээнд иргэний үнэмлэхийн лавлагаа, улсын бүртгэлийн лавлагаануудыг түлхүү авч байна. Аймгийн хэмжээнд нийт давхардсан тоогоор 11,065 иргэн үйлчлүүлсэн. Мөн аймгийн төрийн 2 байгууллагын үйлчилгээг цахимд шилжүүлж e-mongolia.mn системд оруулахаар судалж байна.	70%
9.	6	Төрийн байгууллагын сургалтын орчин сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах бодлогыг хэрэгжүүлэх	50.0 ОНТ	Сургалтад хамрагдсан албан хаагчийн хувь	90	95	Удирдлагын академийн ахлах түшмэлийн сургалтад 8 албан хаагч, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 12 албан хаагч, анх томилогдсон 14 албан хаагчийг улсын төсвийн хөрөнгөөр сургалтад хамруулсан. Хувийн зардлаар 5 албан хаагчийг сургаж, мэргэшсэн. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтад аймгийн	90%

							<p>хэмжээнд нийт 540 төрийн албан хаагчийг хамруулсан. Хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байранд нь албан хаагчдыг чадавхжуулахаар Улаанбаатар хот, аймаг, сумдад зохион байгуулагдсан "Сэтгэлгээний өөрчлөлт" сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад 2, Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад 1, "Төрийн албаны манлайлал" говийн бүсийн нэгдсэн зөвлөгөөнд 120 албан хаагч, БНХАУ-д цахим худалдаа, цахим системийн талаар туршлага судлах сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан. Тайлант онд төрийн албан хаагчийг сургаж дадлагажуулах, чадавхжуулах танхимын 16 сургалтад 523 төрийн албан хаагчийг хамруулсан.</p> <p>Нийт аймгийн хэмжээнд 1063 албан хаагчийг танхим болон цахим хэлбэрээр чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтад хамруулсан.</p>	
3.Төрийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.								
10.	1	“Цахим-Дорноговь” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	5,000.0	Төрийн цахим үйлчилгээний тоо	1800	1850	<p>Төрийн цахим үйлчилгээний e-mongolia системээр дамжуулан иргэн, аж ахуй нэгжид нэг цэгээс түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж "ХурДан" төвийн цэгийг 14 сум болон Сайншанд суманд 2 салбар шинээр байгуулж нийт 16 цахим үйлчилгээний "ХурДан" төвийн цэг ажиллаж байна. Тайлант хугацаанд 8250 үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Сайншанд сумын нийтийн эзэмшлийн гэр бүлийн талбай, тэмээтэй талбай, офицерын талбай, аймгийн төв талбайд утасгүй интернэтийн бүсийг цахимыг зөв зохистой ашиглах, мэдээ мэдээллийг хурдан шуурхай хүргэх зорилгоор байгуулж ажилласан. Цаашид аялал жуулчлал, нийтийн эзэмшлийн 3 байршилд нэмэгдүүлэхээр судалгааны ажил хийж байна.</p> <p>2025 онд автобусны хяналтын систем, аймгийн мэдээллийн нэгдсэн сангийн системийг бий болгохоор судалгаа шинжилгээний ажил хийгдэж байна. "ХурДан"</p>	90%

							төвөөр дамжуулан 43 байгууллагын 478 үйлчилгээг хурдан төвөөс оператор системээс авах боломжийг бүрдүүлсэн.	
11.	2	Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН", 24/7 цагаар ажиллах "СМАРТ" цэгийн тоог нэмэгдүүлж, киоск, хөдөлгөөнт цэг, төхөөрөмжүүдийг үе шаттай нэмэгдүүлэх	24.0	Смарт цэгийн тоо	5	8	Тайлант хугацаанд төрийн үйлчилгээний КИОСК төхөөрөмжийг 2 байршилд ажиллуулж нэг дороос төрийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 7 байршилд өөрөө өөртөө үйлчилж төрийн үйлчилгээг авах боломжтой КИОСК төхөөрөмжийг байршуулаад байна. Цаашид 14 сумын "ХурДан" төвийн цэгт КИОСК төхөөрөмжийг байршуулж 24/7 ажиллуулах ажлыг 3 улиралд хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.	90%
12.	3	Төрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд инновацыг нэвтрүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлж, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх	2.0	Төрийн байгууллагын дотоод системийн ашиглалтын хувь	50	60	Аймгийн хэмжээнд нийт 40 байгууллагын 120 албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх, ERP дотоод системийн ашиглалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулсан. Тайлант хугацаанд ERP дотоод системийг шинээр 4 байгууллага ашиглаж нийт 179 байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, системийг 54%-тай ашиглаж байна. Мөн иргэдийн цахим мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр "ахмадаа сонсьё", "иргэдээ сонсьё" гэх мэт сургалтуудыг багийн ажлын албатай хамтран нийт давхардсан тоогоор 6 удаагийн сургалтаар 1370 иргэнд өгч ажилласан.	90%
4.Гадаад харилцааг тогтвортой өргөжүүлэн хөгжүүлнэ.								
13.	1	Япон, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс орнуудтай "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	-	Тогтвортой хамтын ажиллагаатай гадаад улс, орны тоо,/ хамтран ажиллах арга хэмжээний тоо	10/12	10/13	Дорноговь аймаг нь дэвшилтэт технологи, шинэ зах зээлд гарах боломжийг ашиглан хил дамнасан худалдааг нэмэгдүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БНСУ, Япон, БНЭУ зэрэг улсуудын бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Тухайлбал, БНСУ болон Япон улстай хамтран хөдөө аж ахуй, шинэ технологи, эрчим хүчний салбарт хамтын ажиллагаа өргөжүүлэх зорилгоор гэрээ байгуулахаар санал солилцож байна. Одоогийн байдлаар аймгийн 2 агрономич Япон Улсын Шизуока мужид хүнс, хөдөө аж	90%

							<p>ахуйн чиглэлээр 48 хоногийн туршлага судлах сургалтад хамрагдаад ирсэн. БНСУ-ын Кимжэ хот нь техникийн дэвшилтэт технологи, инновацын шийдэл ашиглан олон төрлийн салбарт амжилттай ажиллаж буй хот бөгөөд Дорноговь аймгийн удирдлагууд болон мэргэжилтнүүд тус хотын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл зэрэг салбар дахь туршлагатай хүмүүс, байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлж байна. Тус хотын захирагчийн зүгээс аймгийн Засаг даргатай хамтран ажиллах санамж бичиг байгуулах санал тавьсан нь судалгааны шатандаа явж байгаа бөгөөд тус санамж бичиг байгуулагдсанаар техникийн шинэчлэл, шинэ бүтээгдэхүүнүүдийн хөгжүүлэлт, байгаль орчинд ээлтэй технологиуд болон аж үйлдвэрийн үйл ажиллагааг автоматжуулах чиглэлээр хамтран ажиллах төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой болно. Мөн англи хэлний сургалтын шинэ арга барилуудыг судалж, багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор аймгийн англи хэлний 10 багш тус улсад туршлага судалсан. МУ-ын ЗГ-ын 14 мега төслийн нэг болох Газрын тос боловсруулах үйлдвэрийн ЕРС-4 багц ажил буюу үндсэн үйлдвэрийн барилга байгууламж, газрын тос боловсруулах ажлын төсөвт өртөг нэмэгдэх болсонтой холбогдуулан аймгийн Засаг дарга БНЭУ-ын Засгийн газар, Эксим банк болон бусад холбогдох газрын удирдлагуудтай ажил хэрэгч уулзалт зохион байгуулсан.</p>	
14.	2	Хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, бизнес, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт гадаад түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх	-	Хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо	3	4	<p>Хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад улсуудтай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх, аймгийн түүх соёлыг сурталчилж, ирж буй жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Дорноговь аймаг нь олон улсын аялал жуулчлалын арга хэмжээнүүдэд өргөнөөр оролцож, тусгайлан урьсан гадаадын жуулчдыг хүлээн авч, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг танилцуулах, аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг зохион</p>	70%

							байгуулж байна. Тухайлбал, энэ оны 8-р сард БНСУ, Япон, Хятад, Орос зэрэг орнуудаас жуулчдыг урьж, орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээ, шинэ маршрут, байгалийн нөөцүүдийг танилцуулсан олон улсын аялал жуулчлалын өдөрлөг зохион байгуулахаар бэлтгэж ажлаа хангаж байна. Түүнчлэн, гадаадын жуулчны агентлагуудтай хамтран аяллын маршрут, багц аялал хөгжүүлж, аймгийн аялал жуулчлалын зах зээлийг тэлэх, шинэ зах зээлд гарах боломжийг бүрдүүлж байна. Жишээ нь Япон улсын Шизуоца мужийн хувийн хэвшлийн салбарын төлөөллүүдтэй хамтран "Антенa шоп" байгуулах ажлыг төлөвлөсөн. Тус аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч, сувилагч нар нь Бугат хотын эмнэлгийн байгууллагуудад зочилж, шинэ эмнэлгийн тоног төхөөрөмжүүд, мэс заслын шинэ арга техникийг ашиглах туршлага, мэдлэгээ өргөжүүлсэн. Энэ аялал нь мэс заслын орчин үеийн техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, мөн эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой байсан бөгөөд аймгийн эрүүл мэндийн салбарт чухал ач холбогдолтой болсон. Эрхүү мужид 7 сард зохиогдох Ёрдын наадамд Монголын уламжлалт соёл, урлагийг дэлхийд сурталчлан оролцох зорилгоор Саранхөхөө театрын 15 уран бүтээлч оролцож, монголын ардын урлаг, дуу бүжиг, жүжигчилсэн тоглолт үзүүлэхээр бэлдэж байна.	
15.	3	"Нэг цонх-Нэгдмэл гадаад бодлого"-ыг үргэлжлүүлж, ОХУ, БНХАУ-тай тогтоосон түншлэлийг эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд өргөжүүлэх	-	Гадаадын төсөл хөтөлбөр, хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	3	4	ОХУ-ын Эрхүү мужийн Амбан захирагч, аймгийн Засаг дарга нар хамтран байгуулсан аймаг, мужийн хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийн хүрээнд 2025 оны 4-р сард Дорноговь аймгийн Засаг дарга ОХУ-ын Эрхүү мужид албан айлчлал хийж, эдийн засаг, соёл, тээвэр логистикийн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар Эрхүү мужийн удирдлагуудтай уулзаж аймаг, муж хооронд хил дамжсан худалдаа, боомтын үйл ажиллагааг сайжруулах, шинэ тээвэр	70%

							логистикийн маршрутуудыг судлах, соёлын солилцоог дэмжих зорилгоор урлагийн байгууллагууд хамтран арга хэмжээ зохион байгуулах, хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал солилцсон нь хоёр талын харилцааг гүнзгийрүүлэхэд түлхэц болсон. Энэхүү хамтын ажиллагааг ГХЯ-ны Бодлогын газар, Монгол Улсаас ОХУ-д суугаа Ерөнхий консулын газар дэмжиж ажилласан. Мөн БНХАУ-ын Замын-Үүд дэх ерөнхий консулын газрын дэмжлэгээр 2025 оны 3-р сард Дорноговь аймгийн ИТХ-ын дарга тэргүүтэй 12 хүний бүрэлдэхүүнтэй баг ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт албан айлчлал хийж, уулзалтаар байгаль орчин, сэргээгдэх эрчим хүч, эрүүл мэнд, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэлэлцсэн. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Бугат, Шилийн гол, Улаанцав аймгуудын найрсаг харилцаа, хил залгаа боомтын хөгжил, мэргэжилтэн солилцох хөтөлбөрийн талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2025 оны 01/349 дугаартай албан бичгээр ГХЯ-ны Хөрш орнуудын газарт албан айлчлалын саналыг Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.	
5.Гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг сайжруулна.								
16.	1	Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулах нэгдсэн стратеги бүхий цогц эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх.	-	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулах дадлага сургууль зохион байгуулсан тоо	4	4	Аймгийн Засаг даргын “Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил” мөрийн хөтөлбөр, Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан Төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу тайлант оны 05 дугаар сард Хөвсгөл суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Өргөн, Мандах сумдад Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль, Хатанбулаг, Сайхандулаан сумдад Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг тус тус зохион байгуулж, тус сумдын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын	70%

							мэргэжлийн ангийн 370 томилгоот бүрэлдэхүүн, 450 иргэнийг хамруулсан. Мөн Онцгой байдлын газраас 2025 онд зохион байгуулах сургалт, дадлагын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 323 удаагийн ангиллын сургалтыг 681 цагийн багтаамжтай зохион байгуулж, 7841 ажилтан, алба хаагч, иргэнд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар эзэмшүүлээд байна.	
17.	2	Стандарттай гамшгийн удирдлагыг хэрэгжүүлэх	-	Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний хувь	10	15	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, Монгол улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу тайлант хугацаанд Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 5 удаа гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийв. Үнэлгээгээр тус аймаг нь зуд, шар усны үер-бага, хээрийн гал түймэр, үерийн-дунд түвшний эрсдэлтэй үнэлэгдсэн тул үнэлгээний тайланг удирдах дээд байгууллагад хүргүүлэн, эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, аймгийн Онцгой комисс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд тус тус танилцуулж ажиллалаа. Хээрийн гал түймрийн эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 08 дугаар тогтоолоор 2.0 сая төгрөг шийдвэрлүүлж, сумдын гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнд дадлага, сургалт зохион байгуулах, хөдөлгөөнт эргүүл хяналтыг сайжруулах ажлыг 2025 оны 04,05 дугаар сард зохион байгуулсан.	70%
6. Хүний эрхийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх, жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах бодлогын зорилтын хүрээнд:								
18.	1	Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, цахим орчин	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээ	4	6	Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Тэмдэглэлт өдөр бий болгох тухай” 22 дугаар тогтоолын дагуу жил бүрийн 01 дүгээр	90%

		дахь ялгаварлал, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, чиглэлээр хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах					сарын 31-ний өдрийг Иргэний нийгмийн өдөр болгон тэмдэглэдэг. Дээрх өдрийг тохиолдуулан идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Иргэний нийгмийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцэх, тэдний санал, хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Уулзалтад ХЭҮК-ийн Дорноговь аймаг дахь референт, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, ахмадын холбооны тэргүүн, эмэгтэйчүүдийн зөвлөл, тусай хэрэгцээт иргэдийн эрх хамгаалах байгууллага, үйлдвэрчний эвлэлийн холбоо, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчид оролцож орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх тайланг танилцуулж цаашид хамран ажиллах талаар санал солилцсон. Түүнчлэн уулзалтын үр дүнд хүний эрхийг хангах хамгаалах чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх, орон нутаг дахь хүний эрхийн нөхцөл байдлыг тодорхойлж хөндлөнгийн тайланг гаргах талаар ойлголтыг өгсөн. Энэ хүрээнд 1. 2025 оны 05 дугаар сард Жендерийн эрх тэгш байдал ба хүний эрхийн асуудлаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ААНБ, холбоодууд, сайн дурын бүлгийн гишүүд, эмэгтэй удирдах албан тушаалтнуудын уулзалтыг зохион байгуулж уулзалтын үр дүнг Хүний эрхийн төлөө хамтдаа өглөөний уулзалт арга хэмжээг өргөн хүрээтэйгээр зохион байгуулахаар төлөвлөсөн. 2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хүний эрхийн боловсрол олгох 12 удаагийн сургалт, 3 өдөрлөгт арга хэмжээг хамтран зохион байгуулсан.	
19.	2	Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлгээнд суурилсан үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээ	1	3	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дугаар тушаалаар батлагдсан 2024 оны Орон нутаг	90%

							дахь хүний эрхийн төлөв байдлын тайланг журамд заасан хугацаанд нь тайлагнан ажилласан. Тус тайланг 21 аймаг 9 дүүргийн хэмжээнд үнэлж Дорноговь аймаг эхний 1-2 дугаарт эрэмбэлэгдсэн эерэг үзүүлэлттэй байна. Орон нутгийн хувьд бүлгийн эрхийн асуудал болон хүний эрхийн төрөлд нийцүүлэн орон нутагт хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа тайлагнасан. Тус тайлангаар орон нутгийн нөхцөл байдлаа тодорхойлж цаашид хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх, бүлгийн эрхийн асуудалд онцгойлон анхаарах нь зүйтэй гэх дүгнэлтэд хүрсэн. Энэ хүрээнд хүүхэд, эмэгтэйчүүд, малчин, цагдан хоригдсон, баривчлагдсан хүн, бэлгийн чиг баримжаа өөр буюу ЛГБТИК-хүний эрхийг хангах, нийт иргэдэд хүний эрхийн боловсрол олгох ажлыг цахимаар, гарын авлага, мэдээлэл, сургалтаар дамжуулан хүргэн ажилласан.	
20.	3	Зорилтот бүлгийн эрхийг хангах, эрхийн зөрчлөөс сэргийлэх, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээ	2	4	Бүлгийн эрхийг хангах хүрээнд 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хоригдох байрны хүүхэд, эмэгтэйчүүдийн хорих ерөөний орчин нөхцөлийг сайжруулахаар аймгийн Засаг даргаас 8.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2.Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолоор “жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулах”-ыг хориглосон. Хүүхдийн эрхийн тухай хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумдын Засаг дарга буюу хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт аймгийн Засаг даргаас чиглэл хүргүүлсэн. Мөн 14 сумын ЗДТГ-ын Хууль зүйн мэргэжилтнүүдийг хүний эрхийн сургагч багшаар бэлтгэхээр төлөвлөөд байна. Тус бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан	90%

							албан хаагчдыг чадавхжуулах ажлыг зохион байгуулсан.	
Иргэний улс төрийн эрх, эрх чөлөө хангагдах боломжийг бүрдүүлэх бодлогын зорилтын хүрээнд:								
21.	1	Иргэний нийгмийн байгууллагын санаачилга, оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Ахмадын хороонд 70.5 сая, Эмэгтэйчүүдийн холбооны орон нутаг дахь салбарт 10.0 сая, Улаан загалмайн хороонд 20.0, тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдэд 135.0 сая, "Төвшин сайхан" ахмадын амралт сувиллын газрын үйлчилгээг 225.0 сая нийт 460.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлэн зохион байгуулсан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Мөн иргэний нийгмийн байгууллагын болон иргэдийн хариуцлагатай оролцоо, хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний хороо байгуулах, хяналт шалгалтын ажлын хэсэг бусад шийдвэрт санал авах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан хамтран ажиллаж байна.	70%
22.	2	Төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, идэвх оролцоог сайжруулах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Монгол Улсын Засгийн газрын 2008 оны "Тэмдэглэлт өдөр бий болгох тухай" 22 дугаар тогтоолын дагуу тэмдэглэн өнгөрүүлдэг Иргэний нийгмийн өдөр аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Иргэний нийгмийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, санал, хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Иргэний нийгмийн байгууллагын болон иргэдийн хариуцлагатай оролцоо, хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний хороо байгуулах, хяналт шалгалтын ажлын хэсэг бусад шийдвэрт санал авах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан, ТББ-уудыг чадавхжуулан, идэвх оролцоог сайжруулах зорилгоор ОНТ-өөс 460.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлэн хамтран ажилласан.	70%
7.Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах бодлогын зорилтын хүрээнд:								

23.	1	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, бүх төрлийн соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил хийж, авлигыг мэдээлэх, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, хариуцлага нэхэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх</p>	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>"Авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор шинээр томилогдсон удирдах албан тушаалтнууд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөлөл, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагч, эрх бүхий албан тушаалтнуудад 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 380 гаруй албан хаагчид, 1800 гаруй иргэдэд 14 удаагийн мэдээллийг хүргэн ажилласан. Түүнчлэн авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах "товш"-аппликэйшн, гомдол мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаар, авлигын хор хөнөөлийг таниулах бүх төрлийн шторк мэдээллийг цахим байгууллагын цахим хаягаар сурталчлан ажилласан.</p> <p>Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 14,2 сая төгрөгийн үнэ бүхий цахим ухаалаг дэлгэцийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хүлээлгийн зааланд байршуулж тус цахим дэлгэцээр дамжуулан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ, үйл ажиллагааг видео бичлэг байдлаар хүргэж, авлигыг мэдээлэх тусгай дугаар, авлигаас урьдчилан сэргийлэх шторк мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Тус дэлгэцийг интернэт сүлжээнд холбож иргэд хүссэн мэдээллээ авах, санал хүсэлт гаргах боломжийг бүрдүүлсэн."</p>	90%
24.	2	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Шүгэл үлээх", "Шүүр", "Шилэн" гэх мэт олон нийтийн хяналтын механизмыг бий болгож, Авлигыг мэдээлсэн иргэдийг дэмжин орон нутгийн түвшинд асуудлыг шийдвэрлэх</p>	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Орон нутгийн хэмжээнд 216 төрийн бус байгууллага Улсын бүртгэлд бүртгэлтэй хэдий ч Авлига тэмцэх зорилго бүхий чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ТББ, ИНБ-ийн сүлжээ байхгүй байгаатай холбогдуулан орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, сайн дурын бүлгүүдтэй хамтран ажиллах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ТББ, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн 30 гаруй төлөөлүүдийг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээгээр авлигын шалтгаан нөхцөл, түүнээс сэргийлэх, мэдээлэх чиглэлээр мэдээлэл хүргэсэн. Мөн Говийн хөх</p>	70%

							салхи НҮТББ-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж авлигын эсрэг штор, богино хэмжээний бичлэгээр дамжуулан иргэдэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн тухайн чиглэлээр олон нийтийн хяналтыг бий болгох, авлигыг мэдээлэх талаар цахим нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газраас холбогдох албан тушаалтнуудыг “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх сургалтад хамруулан 14 сумын Засаг даргын Тамгын газрын хууль зүйн мэргэжилтнүүдэд чиглэл өгч, Хууль, эрх зүйн хэлтсийн цахим хуудас, сумдын ЗДТГ-ын цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн. 2025 оны хагас жилийн байдлаар авлигыг мэдээлсэн, тухайн хүнийг урамшуулсан тохиолдол гараагүй байна.	
25.	3	Авлигыг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, мэдээлэгчийн эрхийг хамгаалах, таслан зогсоох арга хэмжээ авах	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг мэдээлэх талаар шинээр томилогдсон удирдах албан тушаалтнууд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөлөл, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагч, эрх бүхий албан тушаалтнуудад 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 380 гаруй албан хаагчид, 1800 гаруй иргэдэд 14 удаагийн мэдээллийг хүргэн ажилласан. Түүнчлэн авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах “товш”-аппликэйшн, гомдол мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаар, авлигын хор хөнөөлийг таниулах бүх төрлийн шторк мэдээллийг цахим байгууллагын цахим хаягаар сурталчлан ажилласан. Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 14,2 сая төгрөгийн үнэ бүхий цахим ухаалаг дэлгэцийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хүлээлгийн зааланд байршуулж тус цахим дэлгэцээр дамжуулан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ, үйл ажиллагааг видео бичлэг	50%

							байдлаар хүргэж, авлигыг мэдээлэх тусгай дугаар, авлигаас урьдчилан сэргийлэх шторк мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Тус дэлгэцийг интернэт сүлжээнд холбож иргэд хүссэн мэдээллээ авах, санал хүсэлт гаргах боломжийг бүрдүүлсэн. Мөн 14 сумын ЗДТГ-ын хүлээлгийн хэсэгт авлигыг мэдээлэх тусгай дугаарыг байршуулсан.	
8.Аливаа гэмт хэрэг зөрчил, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, хандлагыг төлөвшүүлэх бодлогын зорилтын хүрээнд:								
26.	1	Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2025 онд хэрэгжүүлэх 12 дэд бүлэг 51 заалт бүхий төлөвлөгөөг батлан, улирал тутам хуралдан төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл, шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах болон урьдчилан сэргийлэх ажилд нийт 290,2 сая төгрөгийг зарцуулсан. Аймгийн хэмжээнд нийт 20 олон нийтийн цагдааг чиг үүргийн дагуу ажиллуулж тэдгээрийн урамшуулалд 126 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Аймгийн Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр байгууллагын “Дүн шинжилгээ, судалгааны багийг 2 удаа хуралдуулж, тус аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, өссөн гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээний талаар 8 үүрэг чиглэлийг холбогдох газруудад өгч ажилласан.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор орон нутгийн DSB, DTV телевизтэй хамтран “Хуулийн цаг”</p>	70%

							<p>нэвтрүүлгийг сар бүр бэлтгэн хүргэж ажилласнаас гадна байгууллага, хэлтэс, газруудын цахим хуудсаар дамжуулан 32 видео контент, 151 зурагт хуудас байршуулж 199887 иргэн хуваалцаж 221914 иргэний эерэг хандалт авсан.</p> <p>2025 оны эхний 06 сарын байдлаар нийт 421 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 1 нэгжээр буюу 0.2 хувиар буурсан. Гэмт хэргийн улмаас нийт 329 хүн хохирч, үүнээс 17 хүн нас барж, 101 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 1 буюу 5.6 хувиар, гэмтсэн хүн 10 буюу 9.0 хувиар тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас 2379.9 сая төгрөгийн хохирол учирсан нь урьд оны мөн үеэс 5916.0 сая буюу 71.3% буурсан байна</p>	
27.	2	Зам тээврийн осол гэмтлээс, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Зам тээврийн осол хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох чиг үүргийн байгууллагуудаас хамтран “Сар шинэ”, “Уусан бол бүү жолоод”, “Бэлэн бус торгуулийн төлөлт”, “Гэрэл”, “Хамгаалах бүс”, “Автотээврийн хэрэгслийн ангилал, техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”, “Сигнал-1,2”, “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг”, “Мотоцикл ба хамгаалах малгай”, “Ачаа тээвэрлэлт”, “Сумын хяналт”, “Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал”, “Цагаан хаалга”, “Шугаман эргүүл, цагийн менежмент” зэрэг арга хэмжээг зохион байгуулж биелэлт үр дүнг тооцсон. Эдгээр арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвийн болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх “Мэдээлэх самбар”-т зурагт хуудас, стикер наахад 760,0 мянган төгрөг, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээний зардалд 5,4 сая төгрөг, гэмт хэрэг, зөрчлийг баримтжуулах чиглэлээр дрон 6,0 сая, аймгийн төвийн авто замд “Гэрэлт гарц” хийхэд 5,0 сая төгрөг, аймгийн төвийн авто замын эвдрэлийг засварлуулахад 16,6 сая төгрөг, мөн хэвтээ тэмдэглэлийг тодруулах</p>	90%

							болон шинээр хийхэд 31,0 сая төгрөгийг тус тус зарцуулснаас гадна нийт 19602 зөрчил илрүүлж, бэлэн бусаар нийт 18447 хүнд 538,055,000 төгрөгийн торгууль оногдуулсан.	
28.	3	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээ	6	8	<p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, далд үйлдэгдэж буй хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарын аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдийг дахин энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Амар тайван гэр бүл”, “Хүчирхийллийг зогсооё”, “Сум, багийн-Хяналт” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулан үр дүнг тооцож ажилласан. Тус аймгийн хэмжээнд 74 гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол мэдээллийн бүртгэгдсэн ба уг зөрчлийн 45 хохирогч, холбогдогч нартай тухай бүр ганцаарчлан уулзаж хүчирхийллийн хор уршгийн талаар зөвлөгөө өгч, аюулын зэргийн үнэлгээ “Өндөр” гарсан тохиолдол бүрийг тухайн багийн Засаг дарга нарт холбон зуучлах ажлыг зохион байгуулсан. Хамтарсан багийг 15 удаа мэдээллээр ханган, цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтнууд гэрээр нь биечлэн очин нөхцөл байдалтай танилцаж зөвлөгөө өгч, ажилласан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус аймгийн 62 төрийн болон төрийн бус байгууллага Замын-Үүд сумын 49 төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, алба хаагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Энэ оны эхний 5 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн дахин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 145 иргэдийн дэлгэрэнгүй судалгааг гарган дахин хүчирхийлэл үйлдэж болзошгүй судалгаанд хамрагдсан 12 иргэдийн оршин суух хаягаар биечлэн очиж дахин хүчирхийлэл үйлдэхгүй</p>	70%

						<p>байх талаар зөвлөмж, мэдээлэл өгч гэр бүлийн гишүүдийн санал, хүсэлтийг авч шаардлагатай зөвлөгөө мэдээлэл өгсөн.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж зөрчлийн хэрэг нээж шүүхээр шийдвэрлэгдэж Цагдаагийн байгууллагын нэгдсэн санд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн 21 хохирогч /эмэгтэй/-ийн дэлгэрэнгүй судалгааг гарган ажилласан.</p> <p>Мөн 2025 онд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэргийн 32 холбогдогчийн дэлгэрэнгүй судалгаа мөн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн шинжтэй 145 холбогдогчийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж дээрх иргэдийн мэдээллийг нэгтгэн хувийн хэрэг үүсгэж ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг 2025 оны эхний 5 сарын байдлаар 2 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгжээр буурсан.</p> <p>Хүүхдийн эсрэг гэмт хэрэг эхний 5 сарын байдлаар 1 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үе харьцуулахад 1 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.</p>		
29.	4	Хүүхэд, өсвөр үе, оюутан, залуучуудыг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээ	15	20	<p>"Өгөх урлаг" ТББ-тай хамтран өсвөр насны хөвгүүдэд зориулсан "Боловсролоор үлгэрлээ" төсөл арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ар гэрийн анхаарал халамж сул, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй 14-18 насны зорилтот бүлгийн хөвгүүдэд Англи хэл, Сэтгэл зүйн үйлчилгээ, Сайн дурын ажил гэсэн чиглэлээр 7 хоногийн эхний 6 өдрийн 15:00-17:00 цагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж нийт 30 хүүхэд хамрагдсан. 4 багшийн тэмдэглэл судалгаан дээр үндэслэн 200 ном хэвлүүлсэн.</p> <p>Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Амар тайван гэр бүл" арга хэмжээг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын 500, хувиараа хөдөлмөр</p>	90%

						<p>эрхэлдэг 500, малчин 500, ерөнхий боловсролын сургуулийн 450 сурагч, ажилгүй 550, нийт 2500 иргэнд соён гэгээрүүлэх мэдээ мэдээлэл хүргэсэн.</p> <p>Сурагчдын дундах үе тэнгийн дээрэлхэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Эрүүл аж төрөхүй" олимпиадыг Ерөнхий боловсролын 21 сургуулийн 5,7,10 дугаар ангийн 3266 суралцагчдын дунд зохион байгуулж, амжилттай оролцсон анги хамт олныг шагнаж урамшуулсан.</p> <p>"Өсвөрийн сэргийлэгч -2025" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, ЕБС-ийн 8 багийн 64 сурагч оролцож авхаалж самбаа, мэдлэг боловсрол, авьяас билгээ сорьж оролцсон. Тэргүүн байр эзэлсэн багийг говийн бүсийн аварга шалгаруулах "Өсвөрийн сэргийлэгч-2025" тэмцээнд оролцоход аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "АНЗААР" аяныг зохион байгуулж, аймгийн ГХУСАЗСЗ-ийн гишүүн байгууллагын 70 албан хаагч, Сайншандын Ерөнхий боловсролын 1, 2, 3, 5, 6 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдын 125 эцэг эхчүүд, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн 25 багш, 120 оюутнуудыг тус чиглэлээр 4 удаагийн сургалт мэдээлэл хүргэсэн.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сэтгэцийн эрүүл мэнд, донтолт хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, зорилгоор СЭМҮТ-тэй 5 дахь жилдээ хамтран зохион байгуулж, сэтгэцийн эмчийн үзлэг, сургалтыг Айраг, Замын-Үүд, Сайншанд сумын ЕБ-ын 9 сургуулийн 40 сурагчдыг хамруулсан. Мөн "Мансууруулах бодисын хор, хөнөөл", донтох эмгэг" чиглэлээр нийт 41 удаагийн сургалт зохион байгуулж 23</p>	
--	--	--	--	--	--	--	--

							байгууллагын 2374 /ЕБС-ийн 1902 хүүхэд хамрагдсан/ хүнийг хамруулж эрүүл мэндийн боловсрол олгосон нь өмнөх оны сургалтуудтай харьцуулахад 1222 сурагчийг илүү хамруулсан үр дүнтэй байна.	
30.	5	Бүх нийтийн кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх нөлөөллийн ажил хийх	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээ	6	8	Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, цахим болон залилах төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийн талаарх иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Бүх нийтийн кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээний төлөвлөгөө" гарган хэрэгжилтийг хангуулахаар холбогдох байгууллага, сумдад хүргүүлсэн. Кибер халдлагаас сэргийлэх, байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр кибер аюулгүй байдлын зөвлөлөөс сургалт мэдээлэл, арга зүйн зөвлөгөө авахаар хүсэлт өгсөн.	70%
9.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлыг сайжруулна.								
31.	1	Шүүх шинжилгээний албаны Лабораторийн барилгыг шинээр барьж, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээ	1	1	Шүүх шинжилгээний албаны Лабораторийн барилгын зураг төсөв болон тооцоо судалгааг гарган Хууль зүй, дотоод хэргийн сайд болон холбогдох газруудад хүргүүлж ажилласан. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Шүүх шинжилгээний хэлтсийн экологийн шинжээчид шаардлагатай тоног, төхөөрөмжийн зардалд 12,1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, албан хаагчдыг ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.	90%
32.	2	Аюулгүй орчныг бий болгох камерын нэгдсэн системийг үе	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан теле камеруудыг нэгтгэх, хяналт тавих, бичлэг хадгалах, гэмт	90%

		<p>шаттайгаар шийдвэрлэж ногоон бүсийг бий болгох</p>				<p>хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, авто замын хөдөлгөөний зохицуулалт хийх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/748 дугаар захирамжаар Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Телекамерын хяналтын дэд төвийг байгуулж, холбогдох өрөө тасалгаа, байрыг тохижуулан шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн үйл ажиллагааг хэвийн явуулж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/64 дүгээр захирамжаар төвийн бүтэц, орон тоо, ажиллах журмыг батлан Телехяналтын камерын хяналтын дэд төвийн дарга-1, ерөнхий инженер-1, сүлжээний инженер -2, системийн инженер -2 гэсэн нийт 6 албан хаагчийн хэвийн ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, чиглэлийн 22бш, Хөдөлгөөнт /PTZ/ 12ш, Дугаар таних /ANPR/ 9ш, Царай таних 1ш камер нийт 246 камерыг хяналтад авч, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Телекамерын хяналтын дэд төвийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор аймгийн ГХУСАЗС3-ийн 19/01 дугаар тогтоолоор “Теле камерын хяналтын дэд төв”-ийн урсгал засварын ажилд 19.5 сая төгрөг, аймгийн Засаг даргын 2025 оны А/249 дүгээр захирамжаар 17,7 сая төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/73 тушаалаар 2,3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлэж урсгал засвар болон 23 нэр төрлийн 97 ширхэг нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангасан.</p> <p>Теле камерын хяналтын дэд төвд олон нийтийн 4 цагдаа үүрэг гүйцэтгэн гудамж талбай, олон нийтийн газар, замын хөдөлгөөний үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2025 оны эхний 6 сарын байдлаар теле хяналтын камераар</p>	
--	--	---	--	--	--	---	--

							замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн 21 зөрчлийг илрүүлж, холбогдох хуульд заасан арга хэмжээг тооцон ажилласан.	
10.Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах бодлогын зорилтын хүрээнд:								
33.	1	Төрийн архивын баримтын аюулгүй байдал, баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, эх баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн, хамгаалалтын хувь үйлдэж ашиглалтаас чөлөөлөх ажлыг тасралтгүй хийж байна. Энэ оны хагас жилийн байдлаар 13 хөмрөгийн 565 хадгаламжийн нэгжийн 78070 хуудас баримтыг скайнердан хамгаалалтын хувь үйлдсэн. Хамгаалалтын хувь үйлдсэн баримтаас 345 хадгаламжийн нэгжийн 26946 хуудас баримтыг фотошоп программын тусламжтайгаар засварлан ашиглалтын хувь үйлдэж, программд тодорхойлон бичихэд бэлэн болгосон. Цахимжуулсан баримтын тоог өмнөх оны мөн үетэй хариуцуулах 257 хадгаламжийн нэгж, 43531 хуудас баримтаар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн Засаг даргын 2024 оны а/525 дугаар захирамжаар “Төрийн архивын сан хөмрөгийн баримтад нэгдсэн тооллого явуулах комиссын бүрэлдэхүүн, ажлын удирдамж”-ийг баталсан.Төрийн архивын баримтын тооллогыг 2024 оны 11 дүгээр сард эхлүүлж, 2025 оны 05 дугаар сард дуусгасан. Төрийн архивын 246 хөмрөгийн 571 данс бүртгэлтэй 57334 баримтыг тоолж, нэгдсэн дүнг гаргалаа. Тооллогын явцад архивын баримтыг хамгаалалтын хайрцагт хийж, заагуур үйлдсэн.	90%
34.	2	Стандартын шаардлагад нийцсэн Төрийн архивын зориулалтын байр барих, орчин үеийн мэдээлэл харилцаа, холбооны технологи, техник хэрэгслээр хангах ажлыг үе шаттай гүйцэтгэх	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолыг дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийг Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-Архивын хэлтэс болгон өөрчлөн зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар Архивын хэлтсийн бүтэц зохион байгуулалт, түүний дүрэм, даргын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулсан.	

11.Үндэсний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлогын зорилтын хүрээнд:

35.	1	Орон нутгийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хариу арга хэмжээг авах	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Сумдын Засаг дарга нарт “Үндэсний аюулгүй байдлыг орон нутагт хангах бодлого”, “Хил хамгаалалтад туслах хүчний оролцоо” сэдвүүдээр сургалт мэдээлэл хүргэж, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал” номыг албан хэрэгцээнд хэрэглэн, уншиж судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах арга зүйн зөвлөгөөг өгсөн. Эхний хагас жилийн байдлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүний хуралдааныг зохион байгуулж, зарим тусгай чиг үүргийн байгууллагууд орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй асуудал, үүсэж болзошгүй эрсдэл, нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулж, аймгийн Засаг дарга асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэх үүрэг, чиглэлийг өгсөн.	90%
36.	2	Хилийн торон саадыг үе шаттайгаар засварлах ажлыг үргэлжлүүлэх	УТ ОНТ	Хэрэгжилтийн хувь	100	100	Хилийн торон саадыг үе шаттайгаар засварлах ажлын хүрээнд тайлант оны эхний хагас жилийн байдлаар ХЦ-ийн 3 ангийн хил хамгаалалтын ажлыг нягтруулан бэхжүүлэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500 гаруй км өргөст утсан хашааг шинээр байгуулах, сэргээн засварлах, дохиолол, хяналтын нэгдсэн систем суурилуулах ажлыг хийж эхлүүлсэн.	50%
37.	3	Хилийн цэргийн анги, салбарын үйл ажиллагаа, хилчдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	УТ ОНТ	Хэрэгжилтийн хувь	100	100	Аймгийн Засаг даргын 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/27 дугаар захирамжаар Хилийн цэргийн 0168 дугаар ангийн Хяналтын төвийн тохижилт, засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах захиалагчийн эрхийг мөн аймгийн Засаг даргын 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/28 дугаар захирамжаар Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн алба хаагчдын 24 айлын орон сууцыг засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах захиалагчийн эрхийг шилжүүлэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас тус бүр 80,0 сая төгрөг буюу нийт	90%

							160,0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.	
12.Хууль сахиулах чиг үүргийн байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлэх бодлогын зорилтын хүрээнд:								
38.	1	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх	УТ ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	1	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор хилийн 0129 дүгээр ангийн албан хаагчдын 24-н айлын орон сууцны засварын ажилд 80,0 сая төгрөг, 0168 дугаар ангийн хяналтын төвийн тохижилтын ажилд 80,0 сая төгрөг, Дэлгэрэх сумын цагдаагийн байрны их засварын ажилд 124,6 сая төгрөг, терроризмтой тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд зориулж аймгийн Тагнуулын хэлтэст 39,9 сая төгрөг, Шүүхийн шинжилгээний хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмжийн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 50,0 сая төгрөгийг дэмжлэгийг тус тус үзүүлсэн.	70%
39.	2	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	УТ ОНТ	Хэрэгжилтийн хувь	100	100	Түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 23 алба хаагчийн судалгааг гаргаж, алба хаагчдыг үе шаттай хамруулахаар ажиллаж байна.	50%
13. Орон нутгийн төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, өмч хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.								
40.	1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийг батлуулах, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийж байгууллагуудыг төлбөр тооцоо гүйцэтгэх боломжоор хангах	ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан төсөв, түүний сарын хуваарийг Сангийн яаманд хүргүүлэн Монгол Улсын төсвийн нэгтгэлд нэгтгүүлэн Засгийн газрын удирдлага мэдээллийн системд татуулж, төсвийн байгууллагуудын төлбөр тооцоо гүйцэтгэх боломж нөхцөлийг хангасан. Төсвийн орлого бүрдэлтийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр албан даалгаврыг гарган төсвийн орлого бүрдүүлэхэд оролцдог байгууллагуудын ажлын уялдаа холбоог ханган төсвийн бааз суурийг нэмэгдүүлэн, нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгох олон	90%

							<p>талт арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Оны эхний 5 сарын байдлаар улсын төсвийн орлогод 16.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 153.3 хувь, орон нутгийн төсөвт 42.5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 62.2 хувьтай байна.</p> <p>Орон нутгийн төсвийн орлогын биелэлттэй уялдуулан зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэн сум, төсвийн байгууллагуудад олгох төсвийн санхүүжилтийг эрэмбэлэн төрийн албан хаагчдын цалин хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардлуудыг эхний ээлжид санхүүжүүлэн 36.3 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт гаргасан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 39.8 хувь буюу 54.9 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байна.</p>	
41.	2	Төсвийн төлөвлөлтийн ил тод байдлыг хангаж ажиллах	ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Шилэн дансны хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн олон нийтэд мэдээлбэл зохих нийт 69 төсөв санхүүгийн мэдээллийг хуульд заасан хугацаанд буюу тухай бүр, сар бүрийн 8-ны дотор, улирал, бүтэн жилээр gar.mof.gov.mn, dornogovi.gov.mn, ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулж ажилласан.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны хуулийн дагуу аймгийн 14 сумын 48 төсвийн байгууллага, аймгийн төвийн 10 байгууллага, нийт 58 байгууллага цахим хуудсандаа төсөв санхүүгийн мэдээллээ хуулийн хугацаанд нь мэдээлж, байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллаж байгаад хяналт тавьж ажилласан.</p>	90%
42.	3	Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрхзүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөх, төрийн сангийн	ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалыг удирдлага болгон сумдын санхүүгийн албаны тодорхойлсон эрсдэлийн үнэлгээг хүлээн авч нэгтгэн төрийн сангийн 2025 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн</p>	70%

		эрсдлийг үнэлэх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх					<p>Засаг даргын 2025 оны 03 сарын 06-ны өдрийн А/184 захирамжаар батлуулан Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн.</p> <p>Төрийн сангийн 2025 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөний дагуу оны эхний хагас жилд Сайншанд сумын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулан, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Мөн төрийн сангийн удирдлагын цахим системээр 2025.01.02-2025.06.18-ны хооронд дамжуулсан нийт 11,888 гүйлгээг хянан баталгаажуулж, төрийн сангийн дотоод хяналтыг гүйцэтгэж төрийн сангийн үйл ажиллагааны холбогдох журам зөрчсөн 399 гүйлгээг буцаасан.</p>	
43.	4	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн стандартыг хангана.	ОНТ	Нягтлан бодогчийн тоо	45	45	<p>Орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогчдод 2024 оны төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан гаргах арга зүйн сургалтыг цахимаар зохион байгуулж 56 нягтлан бодогчийг хамруулсан.</p> <p>Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 15 төрийн сан, 44 орон нутгийн төсөвт байгууллага, 89 төсөл сан, 10 ОНӨҮГ, 92 тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага, халамжийн сан, 15 орон нутгийн хөгжлийн сангийн нийт 265 нэгжийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн эсэхийг хянан баталгаажуулж, нэгтгэсэн.</p> <p>Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын газарт тайлантай холбоотой судалгаа, нэмэлт тодруулга тайлбарын хамт хүргүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн эцсийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан. Аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны холбогдох газар хэлтэст Төсвийн цагалбарт хугацаанд хүргүүлэн Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн.</p>	90%

44.	5	Аж ахуйн нэгж, байгууллагын тайланг “Санхүүгийн тайлангийн э-баланс” системд бүрэн оруулах, санхүү, бүртгэлийн чиглэлээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмуудыг хэрэгжүүлж нягтлан бодогчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж мэргэшүүлнэ.	ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн И-Баланс программын баазад бүртгэлтэй санхүүгийн тайлан тушаах 1927 аж ахуйн нэгжээс 1410 байгууллага 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаа болох 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор цахимаар илгээснийг хянан баталгаажууллаа. Тайлан тушаалтын хувь 73.1 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад 20 хувиар өссөн, санхүүгийн тайлан гаргах аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх онтой харьцуулахад 408 байгууллагаар нэмэгдсэн буюу 21.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодогч нарт санхүүгийн тайлан гаргах арга зүй, санхүүгийн тайлангийн нэгтгэлийн И-Баланс програмын шинэчлэлийн талаар тухай бүр мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаас гадна 2024 онд шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын захирал, нягтлан бодогчдод Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн талаарх зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан.	90%
14. Боловсролын чанарыг ахиулна.								
45.	1	Дижитал технологи дээр суурилсан тэгш хүртээмжтэй сургалтын системийг хөгжүүлж, ирээдүйн инженерүүд буюу "2И" төслийг хэрэгжүүлэх	-	Сургалтын системийг нэвтрүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоо	21	21	"Журам батлах тухай" МУ-ын Засгийн газрын 2024 оны А/260 дугаар тогтоолоор батлагдсан "Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам"-ын дагуу "Амжилт", "Их нүүдэл", "Eschool" гэсэн 3 төрлийн цахим системийг ерөнхий боловсролын 21 сургуульд нэвтрүүлж, 16204 суралцагчийг хамруулсан. "Амжилт" системийг 18 сургуулийн 13921 суралцагч, "Их нүүдэл" системийг 2 сургуулийн 2166 суралцагч, "Eschool" системийг 1 сургуулийн 117 суралцагч ашиглаж, цахим системээр дамжуулан нийт 14143 суралцагчийн анги дэвшилт, 9 дүгээр ангийн 1296 суралцагч, 12 дугаар ангийн 765 суралцагчийн төгсөлтийг /төгсөлт дэвшилт гэсэн хэллэгтэй юмаа/	90%

							зохион байгуулсан. "Боловсролын мэдээлэл технологийн төв"-ийн esis системээр 33 цэцэрлэгийн 5019 суралцагчийн анги дэвшилтийг зохион байгуулсан. Мөн Medle.mn цахимд байршуулсан 26 контентыг 33 цэцэрлэг сургалтдаа ашиглаж, тус системээр дамжуулан ерөнхий боловсролын сургуулийн 6 багш, 212 суралцагч амжилттай суралцсан.	
46.	2	Унших чадвар, математик сэтгэлгээг хөгжүүлэх агуулга боловсруулан хэрэгжүүлэх	-	Хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо	0	3000	Аймгийн ерөнхий боловсролын 21 сургуулийн 6 дугаар ангийн 1617 суралцагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэг чадвараа хэрэглээ болгох, математикийн судлагдахууны гүйцэтгэлийн үнэлгээний түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор MS1A хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэхээр боловсруулсан. Хөтөлбөрийн үр дүнг хэмжих зорилгоор 2024-2025 оны хичээлийн жилд 5 дугаар ангид суралцаж байгаа суралцагчдаас эхийг уншиж ойлгох чадварын гарааны үнэлгээ тогтооход 56.2%-тай үнэлэгдсэн. Мөн "Багшийн хөгжил-Сургалтын арга зүй" нэгдсэн сургалтаар математик, монгол хэлний судлагдахууны 106 багшид унших чадвар, математик сэтгэлгээг хөгжүүлэх хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулсан. Хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилд төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ба "Натурал тоо", "Аравтын бутархай", "Бүхэл тоон олонлогт үйлдэл хийх " агуулгыг эзэмшүүлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн 6 дугаар ангийн суралцагчдад зохион байгуулна.	90%
47.	3	Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн олон улсын Кембрижийн агуулгыг нэвтрүүлж эхлэх	-	Сургалтад хамрагдсан багшийн тоо	0	70	Олон улсын PISA шалгалтын үнэлгээг ахиулах, Монгол өв соёл, ухаан хөтөлбөртэй уялдуулан дэлхийн боловсролыг орон нутагтаа эзэмших боломжийг бүрдүүлэх зорилгоор Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуульд олон улсын Кембрижийн агуулгыг нэвтрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан. Мөн Улаанбаатар хотод олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын 5 сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлуулах	90%

							<p>менежментийн сургалтад Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн удирдах 5 ажилтан, 2 багш, нийт 7 төлөөллийг хамруулсан. Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн сургуулийн бусад 40 багшид Кембрижийн агуулгыг нэвтрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх менежментийн сургалтыг зохион байгуулж, мэдээллээр хангасан. Хөтөлбөрийн хүрээнд Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн нийт багш нарын англи хэлний түвшнийг сайжруулах, цахимд ажиллах чадварыг дээшлүүлэх чиглэлээр багш нарын англи хэлний мэдлэгийн түвшнийг тогтоож, 3 түвшний сургалтыг тус бүр англи хэлний багш нарыг түшиглэн зохион байгуулж, 38 багшийг хамруулсан. Мөн "Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийг цахим системд нэвтрүүлэх" сургалтыг Сайншанд сумын ерөнхий боловсролын 3, 6 дугаар сургуулийн байгалийн ухааны 15 багшийг хамруулан зохион байгуулж, 140 багшид Mozaik цахим программыг танилцуулж, түгээн дэлгэрүүлсэн.</p>	
48.	4	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр олон улсын хэлний сургалтын төв байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	30	50	<p>Сайншанд сумын хэмжээнд хятад хэл сурах сонирхолтой цаашлаад БНХАУ-ын их, дээд сургуульд суралцах хүсэлтэй 118 суралцагч байгаа судалгааг үндэслэн тэдний сурах, хөгжих боломжийг олгох, орчныг бүрдүүлэх зорилгоор Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийг түшиглэн "Хятад хэлний сургалтын төв" шинээр нээх бэлтгэл ажлыг хангасан. Тус төвд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотоос Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консулын газраас тус сургуулийн багш, суралцагчдын цахим сургалт, гадаад хэлний сургалтыг дэмжин, "Дижитал танхим"-ыг байгуулж, өндөр үзүүлэлт, хүчин чадал бүхий иж бүрэн 19 суурин компьютероор хангасан. Мөн Сайншанд сумын 1, 2, 3, 5, 6 дугаар сургуулийн хятад хэл сурах хүсэлтэй суралцагчдад хэл, соёлын нээлттэй өдөрлөг,</p>	90%

							арга хэмжээг зохион байгуулж, 130 суралцагчийг хамруулсан. Мөн Дорноговь аймаг ОХУ-ын Эрхүү муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэл”, “Улаанбаатар дахь Орос ордон-Оросын Шинжлэх ухаан, соёлын төв-РЦНК”-өөс Иххэт сумын ерөнхий боловсролын сургуульд “Орос хэлний төв”-ийг байгуулсан. Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дэргэд "Хятад хэлний сургалтын төв" 2018 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа ба 2024-2025 оны хичээлийн жилд 300 суралцагч сургалтад хамрагдаж байна. "Дижитал танхим" 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан тул намар үр дүн гарна.	
49.	5	“Сүү”, “Үдийн хоол” хөтөлбөрүүдийг боловсролын сургалтын байгууллагад хэрэгжүүлэх	-	Хэрэгжүүлсэн байгууллагын тоо	3	33	Бага насны хүүхдүүдийн сүүний хоногийн хэрэгцээг хангах замаар эрүүл мэнд, өсөлт хөгжилд дэмжлэг үзүүлж, амьдралын зөв зохистой дадал хэвшилд сургах зорилгоор аймгийн хэмжээний төрийн өмчийн 33 хүүхдийн цэцэрлэгийн нийт 4407 хүүхдийг хамруулан “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. “Сүү” хөтөлбөрийн үр дүнг хэмжих зорилгоор төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 3485 суралцагчийн биеийн өндөр, жинг хянаж, шүдний урьдчилан сэргийлэх үзлэг болон эрдсийн шинжилгээнд хамруулан судалгаа гарган ажилласан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/79 захирамжаар орон нутгийн төсвийн 272.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн ба төрийн өмчийн цэцэрлэгийн суралцагчийг 100% хамруулсан. Мөн орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжин хамтран ажиллаж, “Өгөөж эрдэнэ дэлгэрэх” ХХК, “Цагаан сүүний буян” ХХК, “Борхойн сүү” ХХК-иуд хэрэгцээт сүүг нийлүүлж ажилласан. Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн үзүүлэлт, судалгааг үндэслэн суралцагчдын уураг, амин дэмийн хэрэглээг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй, чанартай хоол хүнсээр хангах, суралцах анхаарал төвлөрлийг сайжруулж, сурлагын чанарт ахиц гаргах зорилгоор “Үдийн	100 %

							хоол” хөтөлбөрийг аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 21 сургуулийн 6-9 дүгээр ангийн нийт 5720 суралцагчийг хамруулан хэрэгжүүлсэн. Аймгийн Засаг даргын 2025 оны А/81 захирамжаар “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвийн 926.6 сая төгрөгийг шийдвэрлэсэн ба “Үдийн хоол”-ыг ерөнхий боловсролын 19 сургууль өөрийн цайны газарт бэлтгэн хүргэж, 2 сургууль гэрээ байгуулан ажилласан. “Үдийн хоол” хөтөлбөрт хамрагдах суралцагчдын насны онцлогийг харгалзан, судалгаа тооцоолол хийж, орц нормын дагуу олгож, өдөрт авах хоолны шим тэжээлийг нэмэгдүүлсэн. Уг үйл ажиллагаагаар “Намайг хамгаал” нөлөөллийн аяны хүрээнд хүүхдүүдээс гарсан санал санаачилгыг дэмжсэн ба 2025-2026 оны хичээлийн жилд сэтгэл ханамжийн судалгаа болон биеийн хөгжлийн ерөнхий үзүүлэлтийн судалгаа авч, эхний үр дүнг тооцно.	
50.	6	“Англи хэлтэй Дорноговь” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	0	100	Ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчдад зориулсан англи хэлний хөтөлбөрийн 2025 оны үйл ажиллагааны 5 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд “Хreading цахим номын сан”-гийн Монгол дахь төлөөлөгч “Лингорс” боловсролын байгууллагын 291.8 сая төгрөгийн санхүүжилтээр “Англи хэлээр уншигч анги” болгох суурь нөхцөлийг бүрдүүлэх, англи хэлний үгсийн санг нэмэгдүүлэх, унших, сонсох, бичих, ярих чадвар болон англи хэлний дуудлагыг сайжруулах, IELTS-ийн шалгалт өгөх бэлтгэлийг хангах зорилгоор “Бүтээлч уншигчид” төслийг аймгийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлсэн. Уг төсөлд ерөнхий боловсролын 21 сургуулийн англи хэлний 74 багш, анги удирдсан 281 багш, 6-12 дугаар ангийн 8305 суралцагчийг хамруулж, амжилттай оролцсон “Бүтээлч уншигчид” төслийн аймгийн шилдэг сургууль, багш, суралцагч, ангиудыг шалгаруулсан. Үр дүнд:	90%

							<p>2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 8 суралцагч IELTS олон улсын шалгалтын 5.5-8.0 оноо авч, 6 суралцагч гадаадын их дээд сургуулиуд руу суралцах хүсэлтээ явуулан хариу хүлээж байна. Мөн тусгай гэрээгээр ажиллаж буй англи хэлний 2 багш, 2 суралцагч IELTS-ийн 7.0-7.5 оноо авсан. БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан "AI үед хүн төрөлхтөн ойртох нь" сэдэвт 32 дахь удаагийн "КОТЕСОЛ" олон улсын хурал, хэл соёлын арга хэмжээнд аймгийн Боловсролын газрын гадаад хэлний ахлах арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний 25 багш хамрагдаж батламж авсан. "Дэээрэт" болон "Энх тайвны корпус"-ын олон улсын байгууллагын гадаад багш нар болон англи хэлний багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгүүд хамтран 3 чиглэлээр 48 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 9000 гаруй суралцагчдыг хамруулан хөгжүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний хөтөлбөрийн 2025 оны эхний хагас жилд төлөвлөсөн ажил 100%-тай хэрэгжсэн ба гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр үр дүнг тооцно. Гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн дүн 2025 оны 10 дугаар сард гарна. Төлөвлөгөөнд санал тусгасан хэрэгжүүлсэн. Сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлэх албан бичиг хүргүүлсэн.</p>	
51.	7	Төрөлжсөн ахлах сургууль байгуулах ажлыг эхлүүлэх	-	Сургалтын төвийн тоо	0	1	<p>Аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил" 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.7 дахь заалт, "Чиглэл батлах тухай" МУ-ын Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/188 дугаар тушаалын дагуу Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийг "Байгалийн ухаан"-ы чиглэлээр төрөлжүүлэхээр судалгаа хийж, бэлтгэл ажлыг ханган, аймгийн Боловсролын газраас 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 201 дүгээр албан бичгээр Боловсролын яаманд хүсэлт хүргүүлсэн.</p>	70%

							Сайншанд сумын 1 дүгээр сургуулийг 2026-2027 онд шат дараатай ахлах сургууль руу шилжүүлэхээр төлөвлөсөн.	
15. Боловсролын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлнэ.								
52.	1	Бүс, анги нийт, нэрэмжит олимпиад зохион байгуулах	-	Амжилт гаргасан багш, суралцагчдын тоо	93	253	2024-2025 оны хичээлийн жилд зүүн бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан олимпиадад математик, мэдээлэл зүйн хичээлийн судлагдахуунаар оролцож, алтан медаль 1, мөнгөн медаль 6, хүрэл медаль 2, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтын байгууллагын улсын олимпиадад газар зүй, монгол хэл, нийгмийн хичээлийн судлагдахуунаар оролцож, алтан медаль 4, тусгай байр 1, улсын төрөлжсөн олимпиадад биологи, техник технологи, газар зүйн хичээлийн судлагдахуунаар оролцож, мөнгөн медаль 3, хүрэл медаль 1 хүртсэн амжилт үзүүлсэн. Өмнөх хичээлийн жилд улс, бүсийн олимпиадад 3 багш, 9 суралцагч шагналт байр эзэлж байсан бол 2024-2025 оны хичээлийн жилд 5 багш, 17 суралцагч шагналт байр эзэлж, медалийн тоо, чанараа 10-аар ахиулсан амжилт үзүүлсэн. Аймгийн хэмжээнд уламжлал болгон жил бүр зохион байгуулдаг "Анги хамт олны олимпиад"-ыг 12 судлагдахуун хичээлээр 2-3 шаттай зохион байгуулж, давхардсан тоогоор 21 сургуулийн 1-11 дүгээр ангийн 53300 суралцагчийг хамруулж, мэдлэг чадвараа сорин амжилттай оролцсоноос давхардсан тоогоор 63 анги, бүлгийн 1800 суралцагч шагналт байранд шалгарсан. Сургалт зохион байгуулах байр танхимын бэлтгэл бэлэн байдлыг хангуулсан.	100 %
53.	2	Дотуур байрны суралцагчдыг хөгжүүлэх "брэнд" төслийг хэрэгжүүлэх	-	Хамрагдсан суралцагчдын тоо	0	400	Дотуур байрны суралцагчдыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл аюулгүй, цэвэр орчныг бүрдүүлэх, амьдрах ухаанд сургах, бизнес сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор "Брэнд" төслийг ерөнхий боловсролын сургуулийн 16 дотуур байранд хэрэгжүүлж, 674 суралцагч, 210 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан. Дотуур байрны	100 %

							багш, суралцагчид саналаа нэгтгэн брэндээ сонгон хамтран хэрэгжүүлснээр суралцагчид өөртөө итгэлтэй, хариуцлагатай, зорилготой хувь хүн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлж, багаар ажиллах чадвар эзэмших, мэргэжлийн чиг баримжааны бодит дадлага туршлагатай болсон. Үр дүнтэй, онцлогтой "Брэнд" төслүүдийн хүрээнд Улаанбадрах сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Хувцас эвхэлт", Сайхандулаан сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Шимт ааруул", Даланжаргалан сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Эртэч хүүхдүүд", Хөвсгөл сумын сургуулийн дотуур байрны суралцагчид "Хөмөл" брэндүүдээ хэрэгжүүлж, бусад дотуур байрны суралцагчдад сайн туршлага аа түгээн дэлгэрүүлсэн.	
54.	3	"Зорилгын хүч" үйл ажиллагааг зохион байгуулах	-	Хамрагдсан суралцагчдын тоо	700	750	Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн суралцагчдыг элсэлтийн шалгалтад бэлтгэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, суралцагчдыг идэвхжүүлэх, шалгалтад амжилттай үнэлгээ авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Зорилгын хүч" үйл ажиллагааг аймгийн хэмжээнд амжилттай зохион байгуулж, урьдчилсан сорилын шалгалтыг 10 судлагдахуунаар 3 удаа авч, шалгалтад давхардсан тоогоор 5092 суралцагчийг хамруулж, сүүлийн сорилын гүйцэтгэл эхний сорилоос 8,2%-иар ахисан. Суралцагчдыг 4 түвшинд хуваарилан, зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй 41 багш, 2077 суралцагчдад сургалт хийж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 11 сургууль элсэлтийн шалгалтад суралцагчдыг идэвхжүүлэх "Нээлттэй өдөрлөг" зохион байгуулж, багш, суралцагчдын бүтээлч үйл ажиллагааны туршлагыг сургуулийн цахим хуудсанд тухай бүр байршуулж харилцан суралцсан. "Нээлттэй өдөрлөг"-т давхардсан тоогоор 7271 суралцагч, 385 эцэг эх, асран хамгаалагч, 103 багш, 5 байгууллага оролцсон. Аймгийн Засаг даргын 2025 оны	90%

							A/284 дугаар захирамжаар элсэлтийн шалгалтад бэлтгэх "Зорилгын хүч" үйл ажиллагааг зохион байгуулахад зориулж, 14.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
55.	4	Орон нутагт "Гүүр" төслийг хэрэгжүүлж, хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцагчдад гадаад, дотоодын сургалтын тэтгэлгийн нэмэгдүүлэх хүртээмжийг	-	Тэтгэлэгт хамрагдсан хүний тоо	0	8	ОХУ-ын Засгийн газрын 100%-ийн тэтгэлэгт Сайншанд сумын ерөнхий боловсролын 1, 2, 3 дугаар сургуулийн 4 төгсөгч "Оросын улс түмний найрамдлын их сургууль", "Москвагийн Эрчим хүчний дээд сургууль", "Екатерина II-ийн нэрэмжит Санкт-Петербургийн уул уурхайн их сургууль", "Н.И.Пироговын нэрэмжит Оросын Үндэсний Судалгааны Анагаах Ухааны их сургууль"-д тус тус суралцахаар болсон. Аймаг, орон нутагт эрэлттэй, тэргүүлэх мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий аймгийн хэмжээнд нэн шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх "Гүүр" төслийн хүрээнд БНСУ-ын Чонжу их сургуультай хамтран ажиллаж, бизнесийн удирдлага, архитектур мэргэжлээр 2025-2026 оны хичээлийн жилд суралцах 6 суралцагчийг тус сургуулийн хэлний бэлтгэлд хамруулсан. Цаашид суралцагчид солонгос хэлний түвшний оноотой болсноор Чонжу их сургуулийн бакалаврын хөтөлбөрт 90-100 хувийн тэтгэлэгт хамрагдах боломжтой. Мөн гадаадын их дээд сургуулиудад суралцах хүсэлтэй суралцагчдад зориулан Тайвань, БНХАУ, Япон, Ирланд, Филиппин, ОХУ, АНУ, Солонгос улсын их дээд сургуулийн талаар мэдээллийг өгөх 7 өдөрлөг, арга хэмжээнд 488 суралцагчийг хамруулсан.	70%
			-	Сургалтын төлбөр олгосон хүний тоо	0	2		
56.	5	Сэтгэл зүйчийн мэргэшүүлэх сургалтад хамруулах	-	Сургалтад хамрагдсан хүний тоо	0	3	Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 9 сургууль, хүүхдийн 1 цэцэрлэг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангагдсан нь өмнөх оноос 3-аар нэмэгдсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 10 сэтгэл зүйч сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 2494 суралцагчид, ганцаарчилсан зөвлөгөөг 585 багш, суралцагчид, сэтгэл зүйн сургалтыг 11540 хүнд хүргэж, нийт давхардсан	70%

							тоогоор 14619 хүнд үйлчилгээ үзүүлсэн. 2025 оны 09 дүгээр сард 3 сургуульд "Нийгэм-сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцахуй буюу SEEL хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, сэтгэл зүйч нарыг үе шаттайгаар мэргэшүүлэх сургалтад хамруулахаар төлөвлөсөн. Хугацаа болоогүй.	
57.	6	"Суралцагч иргэн-суралцагч аймаг" төслийг хэрэгжүүлэх	-	Хамрагдсан хүний тоо	24581	24681	Аймгийн Насан туршийн суралцахуйн төв нь ЮНЕСКО-гийн "Суралцагч хот" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн онцлогт тохируулан "Суралцагч аймаг-суралцагч иргэн" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 2025 оны эхний хагас жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 80%-тай байна. Төлөвлөгөөний дагуу "Суралцагч" өдөрлөг зохион байгуулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар "Суралцагч байгууллага"-аар шалгарсан. Мөн хүүхэд хүмүүжлийн эерэг аргын 8 модуль сургалтыг Насан туршийн суралцахуйн 13 нэгжээр дамжуулан зохион байгуулж, сумдын олон хүүхэдтэй 118 эцэг эхийг хамруулан, хэлэлцүүлэг хийхэд хүүхэд, эцэг эхийн дундах үл ойлголцол, сонирхлын зөрчил, харилцааны бэрхшээлүүд эергээр шийдэгдсэн үр дүн гарсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэд насан туршдаа тасралтгүй суралцах, амьдралын зөв дадал хэвшлийг бий болгох, таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр нийт 22 төрлийн сургалт, 7 төрлийн нөлөөллийн ажил, 5 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, 64 төрлийн богино бичлэг, контент бэлтгэн, нийт 254 удаагийн давтамжтай 20138 иргэнд хүргэн ажилласан. Аймгийн Засаг даргын захирамжаар болон НҮБ-ын Хүүхдийн сангаас аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулахад зориулж нийт 28.7 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	90%
58.	7	"Алтан зул" наадам зохион байгуулах	-	Сургууль, цэцэрлэг, заах	50	50	2025 оны 10 дугаар сард зохион байгуулна.	Хугацаа

				аргын нэгдлийн тоо				боло огүй.
16. Сургалтын орчныг сайжруулна.								
59.	1	Сайншанд сумын 2, 3, 7, 8, 9 дүгээр цэцэрлэг, Айраг, Даланжаргалан сумын цэцэрлэг, Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн их засварын ажлыг хийх	-	Ажлын гүйцэтгэл	0	100	Сургууль, цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 2025 онд орон нутгийн төсвийн 929.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Сайншанд сумын 3 дугаар цэцэрлэгийн засвар, 709.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Зүүнбаянгийн цэцэрлэгийн засвар, 551.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Сайншанд сумын 8 дугаар цэцэрлэгийн засвар, 122.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Айраг сумын цэцэрлэгийн засвар, 172.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Даланжаргалан сумын цэцэрлэгийн засвар, орон нутгийн хөгжлийн сангийн 807.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Сайншанд сумын 9 дүгээр цэцэрлэгийн засварын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 1120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Сайншанд сумын 2 дугаар цэцэрлэгийн засварын ажлын зураг төслийг "Архидеа" ХХК боловсруулж, Барилгын хөгжлийн төвийн магадлангаар хянуулж байна. Иххэт сумын барилгын их засварыг Японы Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн 551.1 сая төгрөгийн санхүүжилтээр, орон нутгийн төсвийн 371.0 сая, нийт 922.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зураг төсвийг тус тусад нь гаргаж, магадлан орохоор хүлээгдэж байна.	70%
60.	2	Аймгийн зарим цэцэрлэг, сургуулийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	-	Тоног төхөөрөмжөөр хангасан байгууллага	0	55	Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/867 дугаар захирамжаар шинээр үүсгэн байгуулсан Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд шаардлагатай 750.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлын тендер шалгаруулалтыг	50%

							2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр нээхэд 1 дүгээр багцад 11 оролцогч, 2 дугаар багцад 4 оролцогч, 3 дугаар багцад 10 оролцогч, 4 дүгээр багцад 2 оролцогч үнийн санал ирүүлж, нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна. Орон нутгийн төсвийн 600.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 сургууль, 33 цэцэрлэгт 36 нэр төрлийн 235 ширхэг гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажлын тендер шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр нээхэд 1 дүгээр багцад "Чиглэл" ХХК, 2 дугаар багцад "Дэвших оргил баялаг" ХХК, "Номин сувд" ХХК, "Чиглэл" ХХК, "Дольфин партнерс" ХХК-иуд үнийн санал ирүүлж, нарийвчилсан үнэлгээ хийхэд 1, 2 дугаар багцад төрийн бус байгууллагын шаардлага хангаагүй хүчингүй болсон. Дахин тендер зарлах хугацаа болоогүй. Нийт 55 сургууль, цэцэрлэгийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	
61.	3	Хөвсгөл сумын сургууль, Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн өргөтгөл, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийн барилга шинээр барих	-	Ажлын гүйцэтгэл	0	100	Орон нутгийн төсвийн 2817.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл сумын ЕБС-ийн өргөтгөл барих, хуучин сургуулийн гадна фасад засварын ажлыг "Хөх оноо" ХХК гүйцэтгэж байна. Хуучин сургуулийн гадна металл фасадын ажил хийгдсэн, шинээр баригдаж буй 2-р давхрын каркасан хийцийн угсралтын ажил хийгдэж, ажлын явц 40%-тай байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийг буулгаж, шинээр 960 хүүхдийн сургууль барих ажлыг "Голомт констракшн" ХХК гүйцэтгэж байна. Барилгын В блокны 3-р давхрын каркасан хийцийн цутгалтын ажил хийгдсэн, А блокны 2-р давхрын каркасан хийцийн угсралтын ажил хийгдэж, ажлын явц 30%-тай байна. Орон нутгийн төсвийн 5465.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга барих ажлын зураг төслийг "Криетив монголиа" ХХК боловсруулж байна.	70%

62.	4	Сайншанд сумын 1-р сургуулийн барилгын их засварын ажлыг хийх	-	Ажлын гүйцэтгэл	0	100	Орон нутгийн төсвийн 161.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн Дотуур байрны гадна засварын ажлын тендерт "Дэнжийн хүү" ХХК шалгарч, гэрээ байгуулан, ажлаа эхлээд байна.	30%
63.	5	Ерөнхий боловсролын сургуулиудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	-	Тоног төхөөрөмжөөр хангасан сургууль	0	21	Орон нутгийн төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 21 сургуульд 19 нэр төрлийн 111 ширхэг гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр нээхэд 1 дүгээр багцад "Чиглэл" ХХК, 2 дугаар багцад "Дэвших оргил баялаг" ХХК, "Номин сувд" ХХК, "Чиглэл" ХХК, "Дольфин партнерс" ХХК-иуд үнийн санал ирүүлж, нарийвчилсан үнэлгээ хийхэд 1, 2 дугаар багцад төрийн бус байгууллагын шаардлага хангаагүй тул хүчингүй болсон. Дахин тендер зарлах хугацаа болоогүй. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/867 дугаар захирамжаар шинээр үүсгэн байгуулсан Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд шаардлагатай 750.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлын тендер шалгаруулалтыг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр нээхэд 1 дүгээр багцад 11 оролцогч, 2 дугаар багцад 4 оролцогч, 3 дугаар багцад 10 оролцогч, 4 дүгээр багцад 2 оролцогч үнийн санал ирүүлж, нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна.	30%
17. Эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.								
64.	1	Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлэх	-	Системд бүртгэгдсэн иргэдийн тоо	3683	3683	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын 18-64 нас, ЕБСургууль, цэцэрлэгийн 3-17 насны 528 иргэдийг хамруулсан. 528 хүнээс А үнэлгээтэй 102 хүн буюу 19,3%, В үнэлгээтэй 186 хүн буюу 35,2%, С үнэлгээтэй 145 хүн буюу 27,5%, D үнэлгээтэй 95 хүн буюу 18%-ийг тус тус эзэлж байна.	50%

							С, D үнэлгээтэй иргэдэд гарын авлага тарааж, өглөөний дасгал, ажлын байрны дасгалуудыг тогтмол хийх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгсөн.	
65.	2	Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулах	-	Сургалт, арга хэмжээний тоо	3	3	Олон Улсын Олимпын Хорооны “Эв санааны нэгдлийн хөтөлбөр”-ийн хүрээнд биеийн тамирын багш, арга зүйч нараар дамжуулан спорт, олимпизмын үзэл санааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, спорт, олимпын хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг хүргэх, хувь хүний хөгжлийг дэмжих, “Олимпын үнэт зүйлсийн боловсролын хөтөлбөр”-т сургах зорилго бүхий сургалтыг 50 спортын дасгалжуулагчдыг хамруулан зохион байгуулсан. Оросын холбооны улс руу Тийболын спортын сургагч багшаар бэлтгэх, сурталчлах, туршлага судлах зорилгоор аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 2 багшийн замын зардалд 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, сургалтад хамруулсан. Мөн аймгийн 6-н сургуулийн биеийн тамирын багш нарыг Улаанбаатар хот руу туршлага судлах Тийболын танхимын сургалтад хамруулж, 750,0 төгрөгийн замын зардлыг шийдвэрлэсэн. Тайлант оны хагас жилийн байдлаар 3 сургалт, мэргэшүүлэх үйл ажиллагаанд 60-н багш, дасгалжуулагч, арга зүйч нарыг оролцуулж, 7,6 сая төгрөгийн замын зардлын дэмжлэг үзүүлээ.	70%
66.	3	Алтанширээ суманд спорт заал барих	-	Ажлын гүйцэтгэл	-	50	Алтанширээ суманд спорт заал шинээр барих ажлыг “ЭИБОЛ” ХХК ОНТ-ийн 1946.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Барилгын каркасан хийцийн угсралт, дээврийн хучилтын ажил, гадна ханын өрлөгийн ажил хийгдэж байна. Ажлын явц 60%-тай байна.	70%
18. Байгаль, түүх, шашин, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.								
67.	4	“GoMongolia” арга хэмжээний хүрээнд “Үлэмжийн чанар”, “Цайны зам”, “Язгуур албан өв” соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион	-	Арга хэмжээний тоо Хүлээн авсан жуулчдын тоо	Дотоод - 88565 Гадаад - 1777	40000 1000	Дорноговь аймаг 2025 оныг “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Дэлхийд ховорт тооцогдох тэмээн сүргийн соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, малчид, тэмээчдээ	50%

		байгуулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлэх					алдаршуулах, тэмээн сүргийг өсгөн үржүүлж, хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Их говийн тэмээ-2025" тэмээчдийн баяр, Улсын зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд монголын уламжлалт ёс заншил, тэмээчдийн соёлыг олон нийтэд таниулан сурталчлах, говь нутгийн бахархал болгон хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах зорилгоор соёлын биет, биет бус өв, тайзны үзүүлбэр, уралдаан тэмцээн, соёлыг сурталчилсан 500 гаруй эд өлгийн зүйлсийг дэлгэсэн гэр үзэсгэлэнг толилуулж, 2 өдрийн турш 1242 хүн үзэж сонирхсон. "Их говийн тэмээ-2025" арга хэмжээг нийт 3000 гаруй аялагч, жуулчид үзэж сонирхохоос гадна МҮОНРТ, NTV, орон нутгийн DTV телевиз болон цахим сувгуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. 2025 оны 05 дугаар сарын байдлаар "Хамарын хийд"-ийн тусгай хамгаалалттай газар болон "Их нарт"-ын байгалийн нөөц газарт дотоодын 62100, гадаадын 334, нийт 62434 жуулчин хүлээн авсан байна. "Тэнгэрийн Хутагт" аялал жуулчлалын фестивалийг 08 дугаар сард зохион байгуулах ажлын хүрээнд "Үлэмжийн чанар", "Язгуур алтан өв" эвент арга хэмжээг зохион байгуулна.	
68.	5	Орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнийг бий болгох иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжих	-	Дэмжлэгийн тоо	1	1	Орон нутгийн брэнд хоол бүтээгдэхүүнийг шинээр гаргах, сурталчлан таниулах зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард улсын Аялал жуулчлалын чиглэлээр сурталчилгаа хийх зэрэглэлтэй нөлөөлөгч Яншункай болон Хятад зах зээлийн салбар холбооны гишүүн байгууллага болох Марко поло аяллын компанитай хамтран Хятад улсын зөвшөөрөгдсөн тикток, вичат, жижиг улаан ном, кюайршөү сувгуудаар Дорноговь аймгийн брэнд хоол, чулуун гоёл, нутгийн онцлогийг бүтээгдэхүүний танилцуулгыг хүргэсэн. Дорноговь аймгийн Орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр "Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн	70%

							шалгаруулах" арга хэмжээг зохион байгуулсан. Тус шалгаруулалтад Дорноговь аймагт үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 7 иргэн, 19 аж ахуй нэгж 27 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 5 аж ахуй нэгжийг шалгаруулсан. Улаанбаатар хотод 11 дэх жилдээ зохион байгуулагдсан "Улаанбаатар экспо" аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын бизнес эрхлэгч 10 иргэн, аж ахуй нэгжийг оролцуулахад зориулж 1,680,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
69.	6	Аялал жуулчлалын контент бэлтгэж, сурталчлан таниулах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Ажлын гүйцэтгэлээр	0	50	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж, ахуй нэгж байгууллага, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, байгалийн тусгай хамгаалалтай цогцолбор бүхий газар, үндэсний урлаг соёлыг зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард улсад сурталчлан таниулах Хятад улсын аялал жуулчлалын чиглэлээр сурталчилгаа хийх зэрэглэлтэй нөлөөлөгч Яншункай болон Хятад зах зээлийн салбар холбооны гишүүн байгууллага болох Марко поло аяллын компанитай хамтран Хятад улсын зөвшөөрөгдсөн тикток, вичат, жижиг улаан ном, кюайршөү сувгуудаар Дорноговь аймгийн брэнд хоол, чулуун гоёл, Хамарын Хийд, байгалийн түүхийн музейн үзвэрийг үзүүлэх шууд дамжуулалт хийн танилцуулгыг хүргэсэн.	70%
70.	7	Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын форум зохион байгуулах	-	Ажлын гүйцэтгэлээр	-	50	Хугацаа болоогүй	Х.Б
71.	8	Сити тур аялалыг зохион байгуулах	-	Ажлын гүйцэтгэлээр	100	50	Хугацаа болоогүй	Х.Б
19. Соёлын боловсролтой, эерэг хандлагатай, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх, идэвх оролцоог нэмэгдүүлнэ.								
72.	1	Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөр хэрэгжүүлэх	-	Хэрэгжүүлсэн боловсролын хөтөлбөрийн тоогоор тооцно	5	3	Аймгийн Боловсролын газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар хамтран сар бүрийн сүүлийн өдрийг "Соёлын өдөр" болгон зарлаж, аймгийн хэмжээнд тогтмол арга хэмжээ зохион байгуулж хэвшсэн.	90%

							<p>Яруу найргаар дамжуулан иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Эх орон өв уламжлал”, “Оюу-ай” шүлгийн уралдаан, иргэдэд эерэг, бүтээлч хандлагыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Үндэсний бичиг соёл, номын баяр-2025” аяныг 16 нэр төрлийн 37 үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж, танхимаар 1800, цахимаар 6400 иргэн буюу нийтдээ 8200 иргэнийг хамрууллаа. Мөн кино урлагаар дамжуулан иргэдэд урлагийн боловсрол олгох зорилгоор Саранхөхөө театр, сумдын соёлын төвүүд 8 төрлийн киног 3600 гаруй иргэн, хүүхэд залууст хүргэсэн. Тайлант онд шинээр 25 боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд нийтдээ 36 боловсролын хөтөлбөрийг 4100 хүүхэд, 500 иргэн хүргэсэн.</p> <p>Тайлант оны хагас жилийн байдлаар Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх 81 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, 16400 иргэнд соёлын боловсрол олгосон.</p>	
73.	2	<p>Үндэсний бахархал, өв соёл, нүүдлийн соёлыг хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн түүх, орчин цагийг хослуулах замаар шинэ үеийн монгол бахархал бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	-	Арга хэмжээний тоо	-	1	<p>"Монгол угсаатан хэл хуурчдын холбоо"-ны тэргүүнтэй хамтран хэл хуурын аялгууг орчин үеийн “beatbox”-ийн хэмнэлтэй хослуулан тоглож, хөгжүүлэх талаар өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж Сайншанд сумын ЕБС-ийн 5 дугаар сургуулийн 90-н багш, суралцагчид оролцсон.</p> <p>Аймгийн МССТ-өөс Монгол орны байгалийн гайхамшигт газрууд, байгалийн түүхэн өөрчлөлт хувьсал зэрэг тус бүр 26 контентыг программ хангамжийн тусламжтайгаар хэрэглэгчдэд бодитой мэт харагдах хиймэл орчин буюу VR 3 ширхэг төхөөрөмжийг нэвтрүүлэн музейн үйлчилгээг орчин цагийн шинэлэг арга барилаар 1700 гаруй хүүхэд, залуус иргэд олон нийтэд хүргэж үндэсний өв соёл, бахархалыг түгээн дэлгэрүүлсэн.</p> <p>Говийн бүсийн анхдугаар зөвлөгөөнөөр говь нутгийн өв соёл, үндэсний бахархлыг сурталчилсан үзэсгэлэн худалдааг зохион</p>	70%

							байгуулж, орчин үеийн чиг хандлагатай уялдуулан 69 брэнд бүтээгчдийн бүтээгдэхүүнүүдийг танилцуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар 3 арга хэмжээг зохион байгуулж, орчин цагийг хослуулах замаар шинэ үеийн монгол бахархал бий болгох арга хэмжээг хэрэгжүүллээ.	
74.	3	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл III" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	25	<p>Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг орон нутагт хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор аймгийн "Соёлын бүтээлч үйлдвэрлэл"-ийн хөтөлбөрийг боловсруулж, 20 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.</p> <p>Тайлант оны эхний хагас жилийн байдлаар орон нутагт соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор "Тэнгэр заяат", "Төмөр хуурын цуурай" бүжгийг шинээр дэглэж, Ноён хутагтын Үлэмжийн чанар, Таван дохио, Гурван шүтээний бүжгээр видео контент бэлтгэн олны хүртээл болгосон.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд говь нутгийн онцлогийг харуулсан "Тэнгэрийн зарлигтай говь нутаг", "Говийн дуу" зэрэг уран бүтээлийг шинээр туурвиж соёлын бүтээгдэхүүн болгосон. Уг уран бүтээлийг бүтээхэд орон нутгаас 12,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний үндэсний нэгдсэн холбооноос санаачлан зохион байгуулсан "Монгол эв нэгдэл" төслийн арга хэмжээ болон МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан "Монгол дархны уламжлал, шинэчлэл" үндэсний анхдугаар чуулганд уламжлалт гар урлалын 2 өвлөн уламжлагчийг хамруулсан.</p> <p>Хүүхдэд зориулсан уран бүтээлийг нэмэгдүүлж, соёл урлагаар дамжуулан хүүхэд багачуудыг хөгжүүлэх, төлөвшүүлэх зорилгоор "Жаргалан зуслан" хүүхдийн дууны уран бүтээлд 10,0 сая, орон нутгийн уран бүтээлчдийг дэмжих, шинэ уран бүтээл туурвихад 15,0 сая төгрөгөөр тус тус дэмжин</p>	90%

							ажилласан. Тайлант оны хагас жилийн байдлаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдэд орон нутгаас 37,0 сая төгрөгийг зарцуулан дэмжлэг үзүүлж ажилласнаар нийт 5 уран бүтээл туурвиж, 3 контент бүтээсэн.	
75.	4	Соёлын бүтээгдэхүүн, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх	-	Дэмжлэг үзүүлсэн тоо	-	1	Алтанширээ сум "Сумын есөн гайхамшигт газар"-ын танилцуулга бүхий контентыг орон нутгийн төсвөөс 500.0 мян төгрөгийн өртгөөр хийлгэж, сумын ЕБС-ийн 140 гаруй сурагчдад танилцуулсан. "Их говийн тэмээ-2025" арга хэмжээний үеэр Шамбала төсөлтэй хамтран өвлийн аялал жуулчлалыг сурталчлан, орон нутгийн уламжлалт өв соёлыг танилцуулсан контент бэлтгэж олон нийтэд хүргэсэн. Мөн "Брайв нь ю Монголиа" ХХК-тай хамтран Хамарын хийд, Ханбаянзүрх хайрханы аялалын сурталчилгааны контент бэлтгэж байна.	50%
76.	5	Орчин үеийн стандартад нийцсэн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлэх	-	Соёлын үйлчилгээний барилга байгууламжийн тоо	17	8	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн соёл урлагийн байгууллагын 4 байгууламжийг барих ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Тайлант оны хагас жилийн байдлаар Сайншанд суманд баригдаж буй 700 хүний суудалтай "Саран хөхөө" театрын барилга 75 хувь, Замын-үүд суманд баригдаж 500 хүний суудалтай Соёлын ордон 95 хувь, Эрдэнэ суманд 200 хүний суудалтай соёлын төв, Дэлгэрэх суманд 320 хүний суудалтай соёлын төвийн барилгын гүйцэтгэл тус тус 35 хувьтай гүйцэтгэлтэй байна. 2025 оны хагас жилийн байдлаар 4 сумын соёл урлагийн байгууллагуудад нийтдээ 24.4 тэрбумын хөрөнгө оруулалт хийсэн.	70%
20. Гэр бүлийн гишүүдийн хариуцлага, оролцоог сайжруулах, хүүхэд хөгжлийн үйл ажиллагаанд тогтмол хамрагддаг хүүхдийн эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ.								

77.	1	Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын гэр бүлийн төлөөх санал санаачилга, сайн дурын идэвхтнийг дэмжих	-	Зохион байгуулсан арга хэмжээ	0	1	Гэр бүлийн гишүүдийн ёс зүй, үүрэг хариуцлага үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ахмадын хороотой хамтран 25-аас дээш жил амьдарсан 11 ахмад гэр бүлийг алдаршуулах алтан хуримын ёслолын "Ханьсахын жаргал" арга хэмжээ, ахмадын "Нумт" шагайн клубтэй хамтран 35 гэр бүлийн шагайн харвааны "Аргайн хосууд" арга хэмжээг тус тус зохион байгуулж, 2.6 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Гэр бүлийн гишүүдийн боловсрол, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг сум бүр "Бүх хайраа гэр бүлдээ" уриа дор эцэг эх, асран хамгаалагчид болон хүүхдүүдийг хамруулан тэмдэглэсэн. Үүнд: Айраг сум гэр бүлийн соён гэгээрүүлэх лекц, Улаанбадрах сум "Хүүхдүүддээ бахархан дуурайх эцэг эх нь байя" арга хэмжээ, Мандах сум орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагууд тухайн өдөр 10%-ийн хөнгөлөлттэй үнээр үйлчлэх үйлчилгээ, Эрдэнэ сум "Үе үеийн үнэт өв-Гэр бүлийн үндэс" 3 үеийн чуулга уулзалт, Замын Үүд сум "Сайн эцэг эх байх зарчим", Сайншанд сум "Эвтэй гэр бүл-эрүүл ирээдүй" зэрэг 6 нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 6500 гаруй иргэнийг хамруулсан.	50%
78.	2	"Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн "Child future" хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх	-	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	88	90	Хугацаа болоогүй.	Х.Б
79.	3	Мэргэжлийн сэтгэл зүйчдийг бэлтгэж, гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Сэтгэл зүйчийн тоо	5	7	Хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг аймгийн Насан туршийн боловсролын суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулж, 14 сумдын 22 Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг хамруулан Гэр бүлийн сургагч багшаар бэлтгэн эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч нарт хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар ойлголт, мэдлэг олгосон. Гэр бүлийн болон хүүхдийн сэтгэл зүйн үйлчилгээ	50%

						<p>зөвлөгөө авах шаардлагатай 5 иргэн, 8 хүүхдийг мэргэжлийн сэтгэл зүйч рүү холбон зуучилсан. Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй, ар гэрийн анхаарал халамж сул 10-16 насны 30 хөвгүүдийг хамруулан "Боловсролоор үлгэрлэе" 100 хоногийн нөлөөллийн сургалтыг сэтгэл зүйчидтэй хамтран зохион байгуулж, англи хэл, сайн дурын ажил болон сэтгэл зүйн үйлчилгээг 7 хоног бүр хүргэн ажиллаж байна. Эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд дээрх сэтгэл зүйн болон сургалт, нөлөөллийн үйлчилгээ үзүүлснээр гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй нөхцөл байдлыг бууруулж, тэдний нийгэмд өөрийгөө илэрхийлэх боломжийг нэмэгдүүлсэн. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 3 хүүхдийг хяналтад авч, хууль эрх зүй, сэтгэл зүй, хүмүүжил, хандлага зан үйл сургалтыг тогтмол зохион байгуулан, эцэг эх асран хамгаалагчидтай нууцын болон хариуцлагын гэрээг байгуулан хяналт тавин ажилласан. Мөн аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 9 сургууль, хүүхдийн 1 цэцэрлэг мэргэжлийн сэтгэл зүйчээр хангагдсан нь өмнөх оноос 3-аар нэмэгдсэн. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 10 сэтгэл зүйч сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 2494 суралцагчид, ганцаарчилсан зөвлөгөөг 585 багш, суралцагчид, сэтгэл зүйн сургалтыг 11540 иргэнд хүргэж, нийт давхардсан тоогоор 14619 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.</p>		
80.	4	Орон нутгийн хүүхэд хөгжил, хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын үүрэг хариуцлага, чадамжийг нэмэгдүүлэн, салбар дундын уялдаа холбоо, үр нөлөөг сайжруулах	-	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан хүний тоо	2/199	4/300	<p>Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг аймгийн бодлогын баримт бичигтэй уялдуулан, зөвлөл хорооны гишүүдээс саналыг тусган баталсан. Орон нутгийн хүүхэд хөгжил, хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын үүрэг хариуцлага, чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөг 5 зорилт, 17 арга хэмжээтэй</p>	70%

						<p>төлөвлөсөн бөгөөд зөвлөлийн хурлыг 1, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хурлыг 3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж, 2025 оны эхний хагас жилийн тайланг хэлэлцүүлсэн ба төлөвлөгөөний хэрэгжилт 40-90 хувьтай байна. Салбар дундын уялдаа холбоог ханган "Гэр бүлийн сургагч багш" бэлтгэх сургалт, "Цагаан шугам, ногоон гэрэл", "Өсвөрийн сэргийлэгч-2025", Хүүхдийн зуслангийн тохижилт мод тарих арга хэмжээ, "Мини робот" өсвөрийн зохион бүтээгчдийн тэмцээн зэрэг 10 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 15000 гаруй хүүхэд багачууд, эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулсан. "Гэр бүлийн сургагч багш бэлтгэх", "Хүүхдийн элч"-ийн сургалт зэрэг 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 32 хүн хамрагдсан.</p>		
81.	5	<p>Гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүйн боловсрол, үүрэг хариуцлага, ёс зүй, үнэ цэнийг эрхэмлэн дээдлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах</p>	-	<p>Нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо</p>	3/450	5/600	<p>Гэр бүлийн гишүүдийн боловсрол, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг сум бүр "Бүх хайраа гэр бүлдээ" уриа дор эцэг эх, асран хамгаалагчид болон хүүхдүүдийг хамруулан тэмдэглэсэн. Үүнд: Айраг сум сэтгүүлч, гэр бүл судлаач Н.Амарсанааг урьж, соён гэгээрүүлэх лекц, Улаанбадрах сум "Хүүхдүүддээ бахархан дуурайх эцэг эх нь байя" арга хэмжээ, Мандах сум орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагууд тухайн өдөр 10%-ийн хөнгөлөлттэй үнээр үйлчлэх үйлчилгээ, Эрдэнэ сум "Үе үеийн үнэт өв-Гэр бүлийн үндэс" 3 үеийн чуулга уулзалт, Замын Үүд сум "Сайн эцэг эх байх зарчим", Сайншанд сум "Эвтэй гэр бүл-эрүүл ирээдүй" зэрэг 6 нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 6500 гаруй иргэнийг хамруулсан бөгөөд иргэн бүр үүрэг хариуцлагаа ухамсарлан, гэр бүлийн үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх, үндэсний өв соёл уламжлал зан заншлыг орчин үеийн амьдралын хэв маягтай хослуулан, 3 үеийн төлөөллийг оролцуулан, ёс суртахууны</p>	90%

							төлөвшлийг олгосон. Нөлөөллийн сургалтын арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 дахин нэмэгдсэн.	
21. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын тогтолцоог хөгжүүлнэ.								
82.	1	Бүх шатны байгууллагад жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх	-	Байгууллагын тоо, хэрэгжилтийн хувь	0	90	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 3 зорилт, 18 заалт бүхий төлөвлөгөөг баталж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын болон гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах соёлыг төлөвшүүлэх бодлого барин 14 сум дэд салбар хороог шинэчлэн байгуулж Засаг даргын эрхлэх хүрээний 15 байгууллага төлөвлөгөө баталсан бөгөөд хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай байна. "Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулагдсан 5 дугаар ээлжийн сургалтад аймгийн удирдах ажилтны төлөөллийг хамруулсан. Аймгийн Эрүүл мэндийн салбар нь 2025 оныг Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласны хүрээнд "Эрэгтэйчүүдийн кабинет"-ын үйл ажиллагааг идэвхжүүлж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлэн 291 эрэгтэйд үзлэг хийж, 7 иргэнд мэс засал хийсэн.	90%
83.	2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлан, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг дэмжих	-	Сургалт, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	8/1500	10/1800	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлах, жендэрийн хэвшмэл байдлыг халах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр "Жендэр ба түүний үндсэн ойлголт", "Эмэгтэйчүүдийн оролцоо ба манлайлал", "Ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт", "Стресс ба менежмент" зэрэг сэдвээр Хүний эрхийн Дорноговь аймаг дахь референт, жендэрийн сургагч багш нартай хамтран 25 удаагийн сургалт зохион байгуулж 965 иргэн, албан хаагчид хамрагдан жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс	70%

							урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголттой болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49,7 хувиар өссөн.	
22. Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулна.								
84.	1	Ахмад настныг шинэ ур чадварт сургах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлэх	-	Нэмэлт орлого олсон ахмадын тоо	916	920	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)“-ны “Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа”-ны Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 16 байгууллагын 5 чиглэлээр ирүүлсэн төсөлд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ахмадын төслийг хүлээн авах ажлыг зохион байгуулж байна. Мөн “Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа”-ны Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 41 ахмадын төслийг хүлээн авч, 25 ахмадад 194,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг авч үзвэл хоол үйлдвэрлэл 8, оёдол 6, төмөр эдлэл 2, газар тариалан 4, сувилал бариа 3, цэвэрлэгээ үйлчилгээ 1, арьс нэхий боловсруулах 1 үйлдвэрлэл эрхлэгч байна. Аймгийн хэмжээнд “Тэтгэвэрт гарах хөтөлбөр”-тэй 65 аж ахуйн нэгж, байгууллагын 152 ахмадыг хамруулан 19 удаа танхим болон цахим хосолсон сургалт зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 1210 ахмад хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс нийт хөдөлмөр эрхэлж нэмэлт орлого олсон ахмадын тоо 32%-иар өссөн үзүүлэлттэй байна.	90%
85.	2	Өсвөр үе, залуучуудад эх оронч, байгаль орчноо хайрлах, хамгаалах, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх хандлагыг төлөвшүүлэх	-	Арга хэмжээний тоо, хамрагдсан залуучуудын тоо	8542	4600	Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хуралдуулж, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, соёл урлаг боловсрол, залуучуудын хөгжил, оролцоо аюулгүй байдал гэсэн 5 чиглэлээр 22 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан 70%-тай хэрэгжүүлсэн.	70%

							Төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх, сумдын залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр СУАЖЗГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 72 тоот албан бичгээр 14 сум, агентлагуудад зөвлөгөө чиглэл хүргүүлсэн. Хувь хүний хөгжил, гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Төв номын сангийн дэргэдэх Америкийн соёл, мэдээллийн төв өсвөр үе, залуучуудад зориулсан 42 хөтөлбөрийг хэрэгжүүлж, салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд сэтгэлзүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх "Стресс менежмент", "Харилцаа хандлага", хууль эрх зүй, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр 14 суманд 34 төрлийн сургалт, арга хэмжээ, "Агаа Эгээ менторшипийн хөтөлбөр", "Оюу-ай" хайрын шүлгийн яруу найргийн наадам, "Tech trend event", "Эртэч өглөө" уулзалт, "Хайрт аавынхаа гэгээн дурсгалд цэцэрлэгт хүрээлэн" зэрэг 19 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 95 төрлийн хөтөлбөрт арга хэмжээ, сургалт үйл ажиллагааг зохион байгуулж, 7416 өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлж сайн дурын үйл ажиллагаанд идэвхитэй хамрагдах, хувь хүний хөгжил оролцоог хангасан.	
86.	3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллага, бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлж, саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй саадгүй үйлчилгээг нэвтрүүлсэн байгууллагын тоо	75	80	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2025 оны А/164 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан бөгөөд 2025 оны үйл ажиллагааны 4 зорилт 25 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан баталсан. Энэ оны хагас жилийн байдлаар Даланжаргалан, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн өрөөг засварлан орчин үеийн стандартад нийцсэн, тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан ариун цэврийн	70%

							өрөөг хүлээж авсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 10 дугаар сард хүртээмжийн нэгдсэн үзлэгийг зохион байгуулна.	
87.	4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг хийж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах	-	Арга хэмжээний тоо, хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо /давхардсан тоогоор/	34/960	35/1000	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах чиглэлээр "Халамжаас хөдөлмөрт 222" арга хэмжээний хүрээнд байнгын асаргаатай хүүхдийн асран хамгаалагч болон хөгжлийн бэрхшээлтэй 192 иргэнд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/68, А/62 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 157 хүүхдийн эцэг эхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон шинэчлэгдэн гарсан дүрэм журмыг танилцуулж, зөвлөгөө мэдээллээр хангасан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хэвтрийн 12 хүүхдэд Австралийн ротари клуб, Хангай сайн дурын нийгэмлэг тэргэнцэр хандивлан нийгмийн амьдралд хэвийн оролцох нөхцөлөөр хангасан. "Эрхэм нандин сувд" ТББ-аас санаачлан зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарын 6 дахь удаагийн нэгдсэн үзлэг оношилгоонд 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй 131 хүүхдэд эрүүл мэнд, дархлаажуулалтын багцыг олгож, "Монгол Солонгосын хамтарсан шим тэжээл судлалын төв"-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдийн эх эцэг, асран хамгаалагчдад "Эцэг эхийн хандлага өөрчлөх, хүүхдийн хоол зүй шим тэжээл"-ийн талаар сургалтыг зохион байгуулсан. Нийт нөлөөллийн 7 арга хэмжээг зохион байгуулан 581 иргэнийг хамруулж, 4,5	70%

							сая төгрөгийг зарцуулан иргэдийн ойлголт хандлагыг төлөвшүүлсэн.	
23. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, амьдралын чанарыг сайжруулна.								
88.	1	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болох хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцэх ажиллах хүчийг сургаж, бэлтгэн ажлын байраар хангах цогц бодлогыг хэрэгжүүлэх	-	Шинээр бий болсон ажлын байрны тоо	1450	1500	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)”-ны Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагааны танхимын мэргэжлийн сургалт, Ур чадварын цахим сургалтын бүртгэлийг 14 сумдад зохион байгуулж, 87 иргэний судалгаа мэдээллийг хүлээн авч баталгаажуулсан. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 333 шинэ ажлын байр бий болсон бөгөөд 81,1 хувь байнгын, 5 буюу 1,5 хувь нь улирлын, 58 буюу 17,4 хувь нь түр шинэ ажлын байр байна.	30%
89.	2	Аймагт хэрэгжүүлж байгаа томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын захиалгат ажил үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх бодлогыг үргэлжлүүлэн ажлын байр нэмэгдүүлэх	-	Томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтаар бий болсон ажлын байранд	281	285	Орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг "Дэнжийн хүү" ХХК, "Айсуй хөгжил" ХХК, "Мунара констракшн" ХХК-тай Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлээр “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар аймагт хэрэгжүүлж байгаа томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын захиалгат ажлын байранд 293 иргэн зуучлагдсан байна.	30%
90.	3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Төсөл хөтөлбөрт хамрагдаж ажлын байртай болсон иргэдийн тоо	595	600	Энэ оны хагас жилийн байдлаар хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)”-г 7 үйлчилгээний 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, 841 иргэнийг хамруулсан. Энэ онд ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийн төслийн хүрээнд 86 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 47	70%

						иргэн, нийт 133 үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг бүртгэсэн. Мөн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар бүртгүүлсэн иргэдэд Бизнес санаагаа хөгжүүлэх, төсөл бичих чиглэлээр Улаанбаатар хотын “Эм эс девелопмент консалтинг” ХХК-ийн дэргэдэх сургалтын төвтэй гэрээлэн сургалт зохион байгуулж 67 иргэнийг хамруулсан. "Танхимын мэргэжлийн сургалт", "Ур чадварын цахим сургалт"-ын бүртгэлийг 14 сумдад зохион байгуулж 87 иргэний судалгаа мэдээллийг хүлээн авсан. “Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох” арга хэмжээнд төсөл, хүсэлт ирүүлсэн 14 сумын 69 иргэний материалыг хүлээн авч, шаардлага хангасан 40 малчин өрхийг 320,0 сая төгрөгөөр малжуулахаар шийдвэрлэсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 345 иргэнийг хамруулан 123 байнгын, 116 түр ажлын байрыг болгосон. Үүнээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд нийт 137 иргэн, 1 хоршоог хамруулан, нийт 764,4 сая төгрөг олгосон.		
91.	4	Гарааны бизнесийг хөгжүүлэх зорилго бүхий “HUB” байгуулах талаар судлах, Залуучуудын “Дундын оффис” ажиллуулах	-	“HUB”-ын тоо	-	1	Гарааны бизнесийг хөгжүүлэх зорилгоор аймгийн "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төв" гарааны бизнесээ хөгжүүлэх, олон нийтэд түгээх маркетингийн сургалтыг хувиараа бизнес эрхлэгч 17 залууг хамруулан зохион байгуулсан. Мөн ажилгүй, ажил хайгч, сонирхогч иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 15-34 насны 72 иргэнийг хамруулан хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийх, сул чөлөөтэй ажлын байрны захиалга танилцуулга, холбон зуучлах богино хугацааны сургалтын бүртгэлийн мэдээллээр хангаж, 32 иргэнд ганцаарчилсан зөвлөн туслалцаа үйлчилгээг үзүүлсэн. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад бизнес санааг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээлэл хүргэх зорилгоор 2024 онд санхүүгийн дэмжлэг авсан “Little paws” жижиг амьтны	30%

							эмнэлгийн үйл ажиллагааны богино бичлэг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан залуу үйлдвэрлэгч "Содон бургер" цехийн үүсгэн байгуулагчтай ярилцлага хийж тус тус цахим хуудсаар дамжуулж, 2800 үзэгчдийн хандалттай авсан.	
92.	5	"Бүтээмжийн хувьсгал"-ыг өрнүүлж, "Чадварлаг ажилтан-Тогтвортой ажлын байр" хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх	-	Хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын тоо	-	5	"Бүтээмжийн хувьсгал"-ыг өрнүүлж, "Чадварлаг ажилтан-Тогтвортой ажлын байр" хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх зорилгоор ажил олгогчийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2 аж ахуй нэгж байгууллагатай ажил олгогчийн урамшуулал олгох гэрээ байгуулаад байна. Үүнд хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 6 сараас дээш бүртгэлтэй иргэнийг ажилд авсан ХААН банкны Дорноговь дахь салбар, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байр хангасан Хилэнц тур оператор ХХК-тай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулсан.	30%
24. Нийгмийн даатгалын, халамж үйлчилгээний чанарыг сайжруулж хамрах хүрээг өргөжүүлнэ.								
93.	1	Иргэдийг нийгмийн даатгалд хамруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	Даатгуулагчдын тоо	22774	26401	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор тайлант оны хагас жилийн байдлаар 13 сум, 1 багт Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээг зохион байгуулж, 1916 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан. Мөн аймгийн Боловсролын газар, АШУҮИС-н салбар сургуультай хамтран "Даатгалтай ирээдүй" 12 удаагийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, 745 сурагч, оюутнуудад мэдээлэл хүргэсэн. НДЕГ-тай хамтран "Даатгуулагчдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 4,7 сая төгрөгийг зарцуулан орон нутгийн төлөөлөл болсон 368 иргэнд мэдээлэл хүргэсэн. Үүний үр дүнд даатгуулагчийн тоо 28977 болж нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад албан журмын даатгуулагчийн тоо 9.8%-иар, сайн дурын даатгуулагчийн тоо 19%-иар тус тус нэмэгдсэн.	100%

94.	2	“Халамжаас-Хөдөлмөрт” зорилтот арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	-	Халамжаас хөдөлмөрт шилжсэн иргэдийн тоо	31	40	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан 401.2-с доош оноотой 14 сумын 1095 зорилтот өрхийг хөгжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2 зорилт 8 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 40%-тай байна. Сонгогдсон 1095 өрхийн 4438 иргэнээс ахмад настан 121, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд 187, 0-18 хүртэлх насны хүүхэд 2377, оюутан 159, өрх толгойлсон эх, эцэг 129 иргэн байна. “Халамжаас-Хөдөлмөрт” бодлого, арга хэмжээний хүрээнд ажил хөдөлмөр эрхэлж байгаа 1455 иргэн, ажил хөдөлмөр эрхлэх чадвартай боловч хөдөлмөр эрхлэхгүй 606 иргэн байна. Үүнээс 25 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ, 8 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн зээлийн өмнөх сургалтад, 8 өрхийн 16 иргэнийг малжуулах арга хэмжээнд, байнгын ажлын байранд 39 иргэн, түр ажлын байранд 29 иргэн, нийт 117 иргэнийг сургалт, төсөл хөтөлбөр, ажлын байранд зуучлах зэргээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн ажилласан.	70%
95.	3	Эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах улсын бодлогыг сурталчлах	-	Нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	2/1300	25/5762	Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдан, 2024 оны 01 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээр иргэн бүр тэтгэврийн мөнгөн хуримтлалтай болж, мөнгөжүүлж эхэлсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хуулийн зохицуулалт 2030 оноос хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 14 суманд 70 удаагийн сургалтаар 3869 иргэнд зөвлөгөө мэдээллийг хүргэсэн бөгөөд 517 хүүхэд тэжээгчээ алдсаны тэтгэврээ хэлбэрээр, 79 даатгуулагч нас барсан гэр бүлийн гишүүний өндөр насны тэтгэврийн 20 хувийг тусгай зохицуулалтын дагуу авах хэлбэрээр өвийн харилцаа хэрэгжиж байна. Мөн аймгийн хэмжээнд 28977	70%

							даатгуулагч тэтгэврийн мөнгөжүүлсэн хуримтлалтай байна.	
25. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.								
96.	1	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна фасад засварлах, Өргөн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих, Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын гадна дулааны шугамын ажлыг үргэлжлүүлэх	-	Ажлын гүйцэтгэл	0	100	Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн 1,124 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өргөн сумын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх тендерт "Дэнжийнхүү" ХХК шалгарч, 2025 оны 06 сарын 02-нд гэрээ байгуулсан. ЭМТ-ийн өргөтгөлийн барилгыг 2025 оны 11 сарын 15-нд хүлээлгэн өгөхөөр төлөвлөж, 06 сарын 18-ны өдрөөс барилгын ажлыг эхэлсэн.	50%
97.	2	Зарим эмнэлгүүдэд тоноглогдсон автомашины парк шинэчлэл хийж,	-	Автомашины парк шинэчлэл	2	6	Аймгийн хэмжээнд яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогсон, туулах чадвар сайтай автомашин шаардлагатай 6 сумын эрүүл мэндийн төвийн хэрэгцээг судалж, Эрүүл мэндийн яаманд 810 сая төгрөгийг төсвийг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлсэн.	30%
98.	3	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт суурин Рентген аппарат худалдан авах, Эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах	-	Худалдан авсан суурин рентген аппарат	0	100	Орон нутгийн төсвийн 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт суурин рентген аппарат худалдан авах тендерт "Сетунара" ХХК шалгарч 06 дугаар сарын 20-нд суурилуулан хүлээлгэн өгөх гэрээ байгуулсан.	30%
99.	4	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулан тогтвор суурьшилтай ажиллуулах эдийн засгийн хөшүүргийг оновчтой, хүртээмжтэй болгох	-	Төлөвлөгөөний хэрэгжилт	95	97	"Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 4 бүлэг 18 заалтын хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Сум, орон нутгийн төсвийн 30.5 сая төгрөгийн санхүүжилтээр 32 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд малжуулах, сургалтын төлбөр, гэр, түлээ нүүрс авахад болон хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заасан бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлсэн. АЗДТГ-аас хэрэгжүүлж буй "Хөдөөгийн сэргэлт", "Төрийн албан хаагчийг орон сууцжуулах" хөтөлбөрт 5 албан хаагчийг хамруулсан. Сумдын Засаг даргатай "Хамтран ажиллах гэрээ" байгуулан анхан шатны 10 ЭМБ-ын 47 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 1,4 тэрбум төгрөгийн өртөг	50%

							бүхий төрийн албан хаагчийн орон сууцанд түрээсийн төлбөргүй амьдрах боломжоор хангасан. Төрийн дээд одон медаль, салбар, аймгийн бусад шагналаар 68 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг шагнаж урамшуулсан. Илүү цагийн цалинг давхардсан тоогоор 1004 албан хаагчид 1,3 тэрбум төгрөг, үр дүнгийн урамшууллыг 153 албан хаагчид 109,8 сая төгрөг, ур чадварын нэмэгдлийг 49 албан хаагчид 16,5 сая төгрөг, АНЭ-ээс бүтээмжийн урамшууллыг нэвтрүүлж 293 албан хаагчид 149,8 сая төгрөг тус тус олгож нийгмийн баталгааг сайжруулсан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд төрийн эрүүл мэндийн 21 байгууллагын 1212 албан хаагчийн 479 буюу 39.5% нь хамрагдаж, 110 өвчлөл илрүүлж 85%-ийг эрүүлжүүлж, 101 албан хаагч хэвтэн эмчлүүлсэн. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болон лавлагаа шатлалд онош тодруулахаар илгээсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний гэр бүлийн 75 гишүүнд 2.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2025 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 93.6 %-тай байна	
100.	5	Хавдрын бай, мэс засал эмчилгээг нэвтрүүлэх	-	Ажлын гүйцэтгэл	0	100	Эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлгийн хавдрын тасгийг 2 их эмчтэй, 10 ортойгоор өргөжүүлж, полихими, хавдрын бай эмчилгээг орон нутагт нэвтрүүлсэн. 2025 оны хагас жилийн байдлаар хөнгөвчлөх эмчилгээнд 178, хими эмчилгээнд 18 хүнийг хамруулж УБ хот явах урсгалыг 23.6%-иар бууруулсан. Мөн мэс заслын 1 эмчийг хавдрын мэс заслын төрөлжсөн мэргэжлээр сургаж, ХСҮТ-ийн мэс заслын тасагтай хамтран орон нутагт ходоод тайрах мэс заслыг 2 удаа амжилттай хийж, эмч мэргэжилтнүүдийг ажлын байранд нь сургаж чадавхжуулсан. Цаашид бай эмчилгээний төрлийг нэмэгдүүлэхээр судалж, 1 эмчийг ажлын байранд сурган, дадлагажуулж байна.	90%
26. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн бүх нийтийн хамралтыг нэмэгдүүлнэ.								

101.	1	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг зохион байгуулах	-	Халдварт өвчний цогц эрт илрүүлэг үзлэг	2000	2500	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ"-г төлөвлөгөөний дагуу халдварт өвчний цогц эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд 2500 иргэн хамруулахаас 3624 иргэнийг хамруулж, шинээр сүрьеэгийн 1 тохиолдол, БЗДХ-ын 100 тохиолдол илрүүлэн 100% эрүүлжүүлсний үр дүнд төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй. Дархлаажуулалтын ач холбогдлыг сурталчлан таниулах, хамрагдалтыг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлснээр товллын дархлаажуулалтын 1 насны бүрэн тунгийн хамралт 96.5% болж өмнөх оны мөн үеэс 8.5%-иар, 2 насны бүрэн тунгийн хамралт 96% болж өмнөх оны мөн үеэс 7.7%-иар тус тус нэмэгдсэн. Нийт халдварт өвчний 310 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 43 болж өмнөх оны мөн үеэс 16.8-аар буурсан. 2025 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөө 96%-тай хэрэгжсэн.	90%
102.	2	"Иргэний эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх" арга хэмжээг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт	81	90	Иргэний эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оныг "Нийгмийн эрүүл мэнд- өрх бүрд- II", "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарлаж, аймгийн Засаг даргын 2025 оны А/198 дугаар захирамжаар 4.0 сая төгрөгийн дэмжлэгтэй "Эрүүл идэвхтэй амьдрал" арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд "Хавдраас сэргийлэх, мэдээлэл түгээх", "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжье" , "Алхам бүрд анхаарал сэрэмжийг нэмж эрсдэлийг бууруулах", "Эрүүл хүүхэд-эрүүл жирэмслэлт", "Сүрьеэгүй ирээдүй бидний нүдээр" , "24/3 ШҮДЭЭ ЗӨВ УГАА-2025" зэрэг 9 удаагийн аян, 45 нээлттэй хаалганы өдөрлөг, 2 төрлийн тэмцээн уралдаан, цахим болон танхимын 409 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 18953 хүнийг хамруулсан нь өмнөх оноос 34 арга хэмжээ 1057 хүнээр нэмэгдсэн. Мөн 29 төрлийн 1644 ширхэг зөвлөмж,	70%

							гарын авлага тарааж хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл зан үйл төлөвшүүлэх эрүүл мэндийн боловсрол олгосон. Арга хэмжээний хэрэгжилт хагас жилийн байдлаар 41%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.6%-р нэмэгдсэн.	
103.	3	Хүн амын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг нэмэгдүүлэхэд хамтарч ажиллах	-	Үзлэгийн хамрагдалт	5	50	МУЗГ-ын санаачилгаар 2022 оноос эхлэн хэрэгжүүлж буй “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг”-ийг аймгийн хэмжээнд лавлагаа шатлалын 2 нэгдсэн эмнэлэг, анхан шатны 17 эрүүл мэндийн төвд зохион байгуулж байна. Үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор “Эрт илрүүлэг-Эрүүл амьдралын эхлэл” уриатай сарын аян өрнүүлж, 215 удаагийн сургалтад 1412 иргэнийг хамруулсан. Үүний үр дүнд 2025 оны хагас жилийн байдлаар 1526 иргэн үзлэгт хамрагдаж, хамрагдвал зохих иргэдийн 36300 буюу 50.4%-ийг эзэлж байгаа нь улсын хэмжээнд нийт үзлэгийн дүнгээр 5-рт эрэмбэлэгдэж байна. Үзлэгээр давхардсан тоогоор 2155 өвчлөл илрүүлж, 39.1%-ийг эрүүлжүүлж, хяналтад авсан. Хорт хавдрын 3 шинэ тохиолдол илрүүлж дээд шатлалын эмнэлэгт илгээн хяналтад авсан.	90%
104.	4	Явуулын үзлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	-	Үзлэгийн хамрагдалт	0	5000	Аймгийн Засаг даргын 2025 оны А/376 дугаар захирамжийн дагуу 13.1 сая төгрөгийн санхүүжилтээр “Явуулын амбулаторийн үзлэг”-ийг 2025 оны 05 сарын 22-оос 06 сарын 23-ны өдрүүдэд 12 суманд зохион байгуулахаар 5 бүс болгон хувааж, үзлэгийн хуваарийг эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэн үзлэгийг эхлүүлээд байна. Үзлэгийн багт дотор, хүүхэд, мэдрэл, эмэгтэйчүүд, арьс, чих хамар хоолой (ЧХХ), ЭХО, уламжлалт анагаах ухаан, мэс засал, лабораторийн 10 нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийж, зөвлөгөө өгч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлнэ. Тайлангийн хугацаанд Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ,	70%

							Зүүнбаян сумдад ажиллаж 1583 иргэнийг хамруулан давхардсан тоогоор 5939 үзлэг, оношилгоо хийж, шинээр 83 өвчлөл илрүүлж, хорт хавдрын сэжигтэй 4 тохиолдлыг лавлагаа шатлал руу илгээсэн. Эмэгтэйчүүдийн эмч аймгийн хэмжээнд хүрэлцэхгүй болсноос шалтгаалж явуулын үзлэгийг бусад сумдад 9 сараас үргэлжлүүлэхээр төлөвлөсөн ба шүдний үзлэгийг нэмэлтээр оруулах чиглэл хүргүүлсэн.	
27. Улс, орон нутгийн хөрөнгө, оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангана.								
105.	1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн мэдээллийг pimis.publicinvestment.gov.mn системд оруулж, санхүүжилтийг олгох, хяналт тавих, тайлагнах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	30	100	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын pimis.publicinvestment.gov.mn цахим системд “Замын-Үүд суманд Ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан барих” ажлын гүйцэтгэгч “Энержипарагон” ХХК-ний гүйцэтгэлийг захиалагч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд хянан баталгаажуулж, гүйцэтгэлийг Сангийн яам руу илгээснээр 996.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Тус ажлын гүйцэтгэлийн явц 100%	70%
106.	2	Улс, орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг олон нийтэд мэдээллэх, сурталчлах ажлыг зохион байгуулах	-	Мэдээллийн тоо	5	15	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх нийт 69,3 тэрбум төгрөгийн 72 төсөл, арга хэмжээ батлагдсан. Тухайн онд худалдан авах ажиллагааг зохион байгуулах 66 төсөл, арга хэмжээнээс 51 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж 77,3 хувийн гүйцэтгэлтэй. Үүнээс Гэрээ байгуулсан 31, тендерийн нарийвчилсан үнэлгээ хийгдэж байгаа 1 , хариу мэдэгдэл хүргүүлсэн 1 , тендер нээх хугацаа болоогүй 17 төсөл, арга хэмжээ, гэрээ байгуулах тухай захирамж тойрч байгаа 1 , дахин тендер зарлах 3 төсөл арга хэмжээ байна. Зарлагдаагүй 15 төсөл, арга хэмжээний зураг, төсөв магадлал хүлээгдэж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 16, Их засварын 4, Замын сангийн 2, ОНХС-ийн 9 нийт 12 төсөл арга хэмжээний гэрээ	70%

							байгуулан ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэл 10-90 хувьтай явагдаж байна. <u>Санхүүжилт өссөн дүнгээр:</u> Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 775,9 сая төгрөгийн, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 3,8 тэрбум төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 3,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 07-ны өдрийн дотор Шилэн дансанд тухай бүр мэдээллийг ил тод байдлаар олон нийтэд түгээж ажилласан.	
28.Төрийн худалдан авах үйл ажиллагааны ил тод, хүртээмжтэй байдлыг хангаж тэгш оролцоо, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн хяналт оролцоог дээшлүүлнэ.								
107.	1	Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хиймэл оюун ухаанд суурилж зохион байгуулах ажилд хяналт тавих	-	Зохион байгуулсан тендерийн тоо	56	10	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх нийт 69,3 тэрбум төгрөгийн 72 төсөл, арга хэмжээ батлагдсан. Тухайн онд худалдан авах ажиллагааг зохион байгуулах 66 төсөл, арга хэмжээнээс 51 төсөл арга хэмжээний тендерийг www.tender.gov.mn цахим системээр зарласан. Тус систем нь Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сангийн яам, Боловсролын яам, Авто тээврийн ерөнхий газар, Монгол банкны зээлийн мэдээллийн сангаас тендерт оролцогчийн холбогдох мэдээллийг хиймэл оюун ухааныг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.	70%
108.	2	Гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг аймаг орон нутагт татах, сурталчлах, мэдээлэл харилцан солилцох чиглэлээр хамтран ажиллах, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	6	Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөр, Дорноговь аймгийн Засаг даргын хамтын ажиллагааны хүрээнд Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл, ая тухтай орчинд суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор сургуулийн иж бүрэн засварын ажлыг хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна.	30%

							Иххэт сумын сургуулийн барилгын их засварын ажлын зураг, төсөв нь 1,099.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй. Санхүүжилтийн эх үүсвэрийг “Өвсний үндэс” хөтөлбөрөөс 700.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 399.2 сая төгрөгийн шийдвэрлэхээр төлөвлөсөн.	
109.	3	Гадаадын хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, хянаж, тайлагнах.	-	Хэрэгжилтийн хувь	50	100	Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрөөс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын ажлын зураг, төсөв, холбогдох баримт, материалыг Япон улсын Элчим сайдын яаманд хүргүүлсэн. Төслөөс шийдвэр ирээгүй байна.	50%
29. Бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.								
110.	1	“Түншлэл ба хөгжил” аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	-	Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төсөл	-	10	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/06 дугаар тогтоолоор батлагдсан “Түншлэл ба хөгжил” аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд 18 иргэн, 8 аж ахуйн нэгжид нийт 1,956 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, 76 хувь нь төслийн үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, 24 хувь нь техник тоног төхөөрөмж татан авах, ажлын байр барих, түүхий эд бэлтгэх зэргээр төслийн суурь нөхцөлийг бүрдүүлэх шатандаа ажиллаж байна. Орон нутгаас хөтөлбөрт хамрагдсан 26 зээлдэгчийн төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж үр дүнг тооцохоор ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, бизнесээ амжилттай удирдахад чиглэсэн мэдлэг, туршлага, олон талт ур чадварыг олгох “Хамтын өсөлт” үйл ажиллагааг зохион байгуулж өрхийн болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, уран бүтээлчид, зам, барилга, аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, уул уурхайн тээвэр, малчид, хоршоологчдын 80 гаруй төлөөллийг	70%

							<p>оролцуулсан. Одоогоор өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 13, яруу найрагч зохиолч 5, зураач урчууд 3, цахим мэдээллийн үйлчилгээ эрхлэгч 1, нийт 22 бизнес эрхлэгч хамтран ажиллаж байна.</p> <p>"Их говийн тэмээ" улсын зөвлөгөөн, тэмээчдийн баярт урилгаар оролцсон 350 гаруй зочид төлөөлөгчид төсөл хэрэгжүүлэгч 14 үйлдвэр эрхлэгчийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжин ажилласан.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд зохион байгуулагдсан "Говийн бүсийн анхдугаар хуралдаан"-ны гадна талбайн үйл ажиллагаанд Дэлгэрэх суманд хэрэгжиж буй "Үрлэн борц" үйлдвэрлэлийн төсөл үйл ажиллагаагаа олон нийтэд танилцуулсан.</p> <p>2025 оны орон нутгийн төсөвт 2.0 тэрбум төгрөгийг тусган баталж, 3 дугаар улиралд төсөл сонгон шалгаруулалтыг зарлахаар төлөвлөөд байна.</p>	
111.	2	"Дорноговьд үйлдвэрлэв" бизнес эрхлэгчдийн төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	-	Ажлын байр	-	20	<p>Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих зорилгоор Аймгийн Засаг даргын 2023 оны А/589 дүгээр захирамжаар Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт 849 м2 газрыг шийдвэрлэж, МҮХАҮТ-ын санхүүжилтээр "Дорноговьд үйлдвэрлэв төв"-ийг барьж ашиглалтад оруулахад бэлэн болсон.</p> <p>Орон нутгаас тус төвийн барилгын гадна талбайд 140 м2 авто зогсоолыг төсвийн 190.0 сая төгрөгийн хөрөнгөө барьж ашиглалтад оруулсан. Тус төв ашиглалтад орсноор Дорноговь аймагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг нэг дор худалдан борлуулах, олон нийтэд сурталчлан таниулах, өрхийн болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах нөхцөл бүрдэх юм.</p>	70%
112.	3	"Их говийн тэмээ" өвлийн уралдаан, тэмээчдийн улсын зөвлөгөөнийг зохион байгуулах	-	Оролцогчдын тоо	1500	-	<p>Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/78 дугаар захирамжаар "Их говийн тэмээ" улсын зөвлөгөөн, тэмээчдийн баярыг Сайншанд сумын 2 дугаар</p>	100 %

							<p>баг, “Гурван замын уулзвар”-т 2 өдөр зохион байгуулсан.</p> <p>“Их говийн тэмээ” улсын зөвлөгөөнд 7 аймгийн 350 гаруй тэмээчин, тэмээчдийн баярт 51 баг тамирчид, 231 хурдан тэмээтэй, 14 сум оролцооны нийт 1146 тэмээ, хүндэтгэлийн гэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн хамтаар оролцсон.</p> <p>Үйл ажиллагааны хөтөлбөр, зардал, талбайн зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдал зэрийг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/06 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хариуцан зохион байгуулсан.</p>	
113.	4	“Говийн бүсийн анхдугаар хуралдаан”-ы хүрээнд тусгай хөтөлбөрт “Түншлэл өдөрлөг”-ийг зохион байгуулах	-	Оролцогчдын тоо	110	-	<p>Монгол Улсын Засгийн газраас “Говийн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан”-ыг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар багт байрлах “Спорт цогцолбор”-т зохион байгуулагдсан.</p> <p>“Спорт цогцолбор”-ын гадна талбайд говийн бүсийн аймгуудын соёлын үйл ажиллагаа, “Түншлэл-Хамтын ажиллагаа”, говийн бүсийн брэнд бүтээгдэхүүн шалгаруулалт зэрэг нэгэн зэрэг явагдсан.</p> <p>Үйл ажиллагааны хүрээнд “Монголын их говийн бахархал уран зураг, соёлын бүтээлч үйлдвэрлэл”, “Говийн бүсийн брэнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээ”, говийн бүсийн 4 аймгийн брэнд бүтээгдэхүүн, хоршоо, аялал жуулчлал, газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэнг нэгэн зэрэг гаргаж иргэд, олон нийтэд сурталчлан борлуулсан.</p> <p>Дорноговь 63, Өмнөговь аймгийн 8 аж ахуйн нэгж, Дундговь 6, Говьсүмбэр 5, нийт 82 иргэн, аж ахуйн нэгж оролцож орон нутгийн онцлогтой бараа бүтээгдэхүүн, соёлын биет болон биет бус өв зэргийг сурталчлан борлуулсан.</p> <p><u>Бүтээгдэхүүний төрөл:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Мал аж ахуй 2 (тахяны аж ахуй) 2. Хүнсний үйлдвэрлэл 52 <p>Сүү, сүүн бүтээгдэхүүн, цагаан идээ, ааруул 17</p>	100 %

						<p>Мах махан, дайвар бүтээгдэхүүн 5 Ингэний хоормог сүү, тараг 16 Бялуу, талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн 5 (Чойр хавсай, катеринг, мазаалай брэнд) Говийн хийцтэй цай 2 Цагаан идээний багц 4 (загсгал) Хоол үйлдвэрлэл 2 (төлөг брэнд) Дахин боловсруулсан бүтээгдэхүүн 1 (лаазалсан болон бууз баншны цех) 3.Хөнгөн үйлдвэрлэл 9 Модон үйлдвэрлэл 3 Үндэсний дээл, хувцас 4 (ноосон малгай, ороолт, бээлий, оймс, урлагийн хувцас) Үнэт эдлэл үйлдвэрлэл – 2 (мөнгөн аяга, хэрэглэл, чулуун гоёл 4. Бэлэг дурсгал 7 Гар урлал 4 (тэмээн жин, мэлмийтэй уут) Арьс, арьсан бүтээгдэхүүн 3 (Монгол бүс, тэлээ, цүнх) 5. Эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 5 (шимт бор, гумины бордоо, тэжээлт бор, малын нэмэлт бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүнүүд) 6. Ахуйн хэрэглээний 3 (агар хувин, тэмээний ноосон хөнжил,) 7. Мод үржүүлэг, үрсэлгээ 4 8. Музей, галерей 6. “Түншлэл-Хамтын ажиллагаа” үзэсгэлэн худалдааг зохион байгуулснаар говийн бүсийн аймгуудын өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид харилцан туршлага судлах, цаашид хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлсэн. Үйлдвэр эрхлэгчид өөрийн бараа бүтээгдэхүүнийг бусад аймгийн үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнтэй харьцуулах, цаашид хэрхэн хөгжүүлэх, анхаарвал зохих асуудлуудын талаар дүгнэлт хийх, бусад аймгийн бүтээгдэхүүнийг нэг дороос нүдээр үзэх нөхцөл бүрдсэн.</p>
--	--	--	--	--	--	--

114.	5	“Түншлэл ба хөгжил” зорилтот хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл авсан иргэн, ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, газар дээр нь ажиллах	-	Хамрагдалтын хувь	-	100	Орон нутгаас хөтөлбөрт хамрагдсан 26 зээлдэгчийн төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах чиглэлийг сумдын Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус 2025 оны 02/..... тоот албан бичгээр хүргүүлсэн. Үр дүнгийн хэрэгжилтийг 6-7 дугаар сард багтаан үнэлж, 2025 оны орон нутгийн төсөвт тусгагдсан 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгох төсөл сонгон шалгаруулалтыг 3 дугаар улиралд зарлахаар төлөвлөөд байна.	50%
30. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн үйлчилгээг бий болгоно.								
115.	1	Хүнсний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг сайжруулж, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт холбогдох стандартыг мөрдүүлэх	-	Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан объект	50	50	Аймгийн хэмжээнд 335 хүнсний худалдаа эрхлэгч, 67 хүнсний үйлдвэрлэл эрхлэгч, 155 хоол үйлдвэрлэл эрхлэгч үйл ажиллагаа явуулдаг ба тайлант онд худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн 17 объектыг (2 объект үйл ажиллагаа зогссон талаар албан бичиг ирүүлж нийт 15 объектод хяналт шалгалт хийхээс) буюу 3.05 хувийг хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөсөн. Эхний хагас жилд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан төлөвлөгөөт 3 удаагийн хяналт шалгалтад хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгчийн 8 объектыг хамруулж, 130 зөрчил, дутагдлыг илрүүлж, илэрсэн зөрчил дутагдлын 49.2 хувийг газар дээр нь бүрэн арилгуулж, 87,5 хувьд улсын байцаагчийн 66 заалт бүхий 14-30 хоногийн хугацаатай албан шаардлага өгч ажилласан. Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад чиглэсэн 4 удаагийн танхимын (Сайншанд-3, Замын-Үүд-1 сумдад зохион байгуулсан) сургалтад 325 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл, 1 удаагийн цахим сургалтад 27 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл, нийт 5 удаагийн сургалтад 352 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулж	70%

							<p>сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.</p> <p>Мөн Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн нийт 65 сурагчдыг хамруулж сургалт зохион байгуулсан.</p> <p>Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус хяналт шалгалтуудад хамрагдсан 415 иргэнд биечилсэн зөвлөгөө, мэдээлэл өгч, арга зүйгээр хангасан.</p> <p>Стандарт, хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лаборатори ирүүлсэн 225 хүсэлтийн 1186 дээж, 1399 сорьцыг, 4403 үзүүлэлтээр шинжилж, шаардлага хангаагүй буюу эерэг үзүүлэлттэй усын 180 дээжийг илэрсэнийг салбарын хяналтын улсын байцаагчид шилжүүлж, шаардлага хангасан буюу сөрөг үзүүлэлттэй 4223 дээжийг сорилтын дүнгээр баталгаажуулсан.</p>	
116.	2	Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт цахим нэгдсэн санг нэвтрүүлж, хөгжлийн хоцрогдлыг арилгах бодлогыг дэмжих	-	Хамрагдсан бизнес эрхлэгч	50	50	<p>Аймгийн хэмжээнд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний 87 төрөл, ангилалд 979 бизнес эрхлэгч идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. "Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн мөрдөх нийтлэг журам"-ын хүрээнд дээрх үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, үйл ажиллагаа эрхлэх нэгдсэн бүртгэлийн системийн хөгжүүлэлт 60 гаруй хувьтай явагдаж байна.</p> <p>Тус аймаг нь Зөвшөөрлийн тухай хуулийн хүрээнд согтууруулах ундаа худалдаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг e-mongolia цахим системээр 2022 оны 09 дүгээр сараас эхлэн хүлээн авч шийдвэрлэж хэвшсэн.</p> <p>Тайлант хугацаанд шинээр нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээний зориулалтаар талбайн ашиглуулах энгийн зөвшөөрлийг e-mongolia цахим системд шилжүүлсэн.</p>	70%

							Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд цахим худалдааны салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд БНХАУ-ын Худалдааны Яамнаас зохион байгуулсан “Монголын цахим худалдааны семинар”-т орон нутгаас 1 төрийн албан хаагчийг хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн. “Түншлэл ба хөгжил” аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрт хамрагдсан Сайншанд сум иргэн "Аймгийн мэдээллийн цахим нэгдсэн сан"-г байгуулах ажлын гүйцэтгэл 80 гаруй хувьтай, 7 төрлийн үйлчилгээнд 31 бизнес эрхлэгчийн бүртгээд байна.	
117.	3	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээний зориулалтаар талбай ашиглуулах энгийн зөвшөөрлийг цахимд оруулах, зөвшөөрлийг олгох	-	Хамрагдсан бизнес эрхлэгч	-	100	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “Харьяа нутаг дэвсгэрт хамаарах нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээний зориулалтаар талбай ашиглуулах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.13-т заасны дагуу аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга олгоно”, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.13-т “Нийтийн эзэмшил гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай ашиглах энгийн зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга олгоно” гэж тус тус заасан байдаг. Холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэн, сумдаас санал авч нэгтгэсэн. Цаашид энгийн зөвшөөрлийг цахим шилжүүлэн төрийн үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй, ил тод байдлыг хангах зорилгоор Эдийн засгийн хөгжлийн яаманд хүсэлт хүргүүлж, https://license.mn/ нэгдсэн системд оруулан туршилтын шатандаа байна.	70%
118.	4	Аж ахуйн нэгж, байгууллагын санал,	-	Шийдвэрлэсэн асуудал	-	10	Аймгийн Засаг дарга, түүний зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийг тухай бүрд холбогдох агентлаг,	100 %

		<p>хүсэлтийн дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай болон энгийн зөвшөөрөл шинээр олгох, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэх</p>				<p>албан хаагчдад уламжилж, хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.</p> <p>2025 оны эхний хагас жилд https://les.e-business.mn/dashboard согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн 461 хүсэлтийг хүлээн авч, 23 аж ахуйн нэгжийн хүсэлтийг 3 удаагийн захирамжаар шийдвэрлүүлсэн.</p> <p>Холбогдох хууль, журмын шаардлага хангаагүй бусад аж ахуйн нэгжийн материалыг хянан зөвлөгөө өгч, хариуг тухай бүрд илгээсэн.</p> <p>Тусгай зөвшөөрөд олгох аймгийн Засаг даргын захирамжийг гэрчилгээгээр баталгаажуулж, улсын тэмдэгтийн хураамжийг холбогдох хуулиар тогтоосон хэмжээгээр нэгдсэн төсөвт төвлөрүүлэн санхүүгийн анхан шатны баримт, хагас, бүтэн жилийн татаврын тайлангаар баталгаажуулан ажилладаг. Тайлант хугацаанд нийт 19,8 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжийг хяналт хэрэгжүүлэгч Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Стандарт, хэмжилзүйн хэлтэс, холбогдох сумдад гарсан даруй хүргүүлэн хамтран ажилладаг.</p> <p>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “Харьяа нутаг дэвсгэрт хамаарах нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээний зориулалтаар талбай ашиглуулах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.13-т заасны дагуу аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга олгоно”, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.13-т “Нийтийн эзэмшил гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай ашиглах энгийн зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга олгоно” гэж тус тус заасан байдаг.</p> <p>Холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн хэмжээнд нийтийн</p>	
--	--	---	--	--	--	---	--

							<p>эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэн, сумдаас санал авч нэгтгэсэн.</p> <p>Цаашид энгийн зөвшөөрлийг цахим шилжүүлэн төрийн үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй, ил тод байдлыг хангах зорилгоор Эдийн засгийн хөгжлийн яаманд хүсэлт хүргүүлж, https://license.mn/ нэгдсэн системд оруулан туршилтын шатандаа байна.</p>	
31.Хариуцлагатай уул уурхайг нэмэгдүүлнэ.								
119.	1	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийг хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;	-	Өргөдөл шийдвэрлэлтийн хувь	100	100	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 7 өргөдлийг хүлээн авч хууль тогтоомжийн хүрээнд судлан Ашигт малтмал, газрын тосны газрын цахим өргөдлийн санд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох боломжгүй дүгнэлтийг үндэслэн 7 өргөдөлд хариу мэдэгдэж, хаасан.	90%
120.	2	Дүйцүүлэн хамгааллын хүрээнд эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлийг холбогдох байгууллага сумдын Засаг дарга нарт чиглэл болгон хүргүүлж, биелэлтэд хяналт тавих	-	Нөхөн сэргээсэн талбай га,		10	Аймгийн хэмжээнд эвдэрсэн газрын тооллого судалгааны ажлыг зохион байгуулж 23 байршилд нийт 626.34 га эвдрэлтэй газар шинээр бүртгэж эвдэрсэн газрын мэдээллийн санд оруулсан. Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах, Өргөн, Сайхандулаан сумдад эзэн холбогдогчгүй эвдрэлд орсон 42,7 га талбай байгаагаас дүйцүүлэн хамгааллын хүрээнд 5 га талбайг нөхөн сэргээхээр төлөвлөж, уул уурхайн 2 компанийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлэхээр хүлээгдэж байна. Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 45 компанийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлж, зэрлэг амьтны тархац нутагт биотехникийн арга хэмжээ авах, усан хангамжийг нэмэгдүүлэх, өөрийн эзэмшлийн талбайн 10 хувьд мод тарих, эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрын нөхөн сэргээх зэрэг ажлуудыг 2025 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх санал зөвлөмжийг хүргүүлж ажилласан.	50%
				Хамгаалсан арга хэмжээний тоо	-	3		

121.	3	"Хариуцлагтай уул уурхай" Говийн бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулах, Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай "Хамтран ажиллах гэрээг" байгуулж, гэрээний хэрэгжилтийг нийтэд ил тод мэдээллэх	-	Ажлын үр дүн хувиар	-	100	Говийн бүсийн зөвлөгөөнийг 3 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн. Дээрх бэлтгэл ажлын хүрээнд аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа "Уул уурхайн бизнес эрхлэгчдийн уулзалт-2025" арга хэмжээг 03 дугаар сарын 17,18,19-ний өдрүүдэд зохион байгуулж 12 сумын 38 аж ахуйн нэгжийн төлөөлөл, зарим сумд, холбогдох байгууллагын төлөөллүүдийн хамт уулзаж орон нутагт уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн мэдээлэл болон тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг харилцан нээлттэй ярилцаж 18 заалт бүхий асуумж мэдээллийг авч, дараах тулгамдаж буй асуудлыг нэгтгэн гаргаж дүн шинжилгээ хийж сумдын Засаг дарга нарт чиглэл болгон хүргүүлсэн.	30%
				Хамтран ажиллах гэрээ/ хэрэгжилт	-	30		
122.	4	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох, цуцлахтай холбоотой саналд иргэдийн оролцоог хангах чиглэлээр мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах	-	Ажлын үр дүн хувиар	100	100	Говийн бүсийн зөвлөгөөнийг 3 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн. Дээрх бэлтгэл ажлын хүрээнд аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа "Уул уурхайн бизнес эрхлэгчдийн уулзалт-2025" арга хэмжээг 03 дугаар сарын 17,18,19-ний өдрүүдэд зохион байгуулж 12 сумын 38 аж ахуйн нэгжийн төлөөлөл, зарим сумд, холбогдох байгууллагын төлөөллүүдийн хамт уулзаж орон нутагт уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн мэдээлэл болон тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг харилцан нээлттэй ярилцаж 18 заалт бүхий асуумж мэдээллийг авч, дараах тулгамдаж буй асуудлыг нэгтгэн гаргаж дүн шинжилгээ хийж сумдын Засаг дарга нарт чиглэл болгон хүргүүлсэн.	70%
32. Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.								
123.	1	Усны сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн	70	75	Галба-өөш, долоодын говийн сав газрын захиргааны даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн ус ашиглалтын байдалд хяналт, шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу ус ашиглагч үйлдвэр, уул уурхайн эх үүсвэрийн	90%

				хувиар тооцно.		<p>болон уурхайн шүүрлийн ус, цэвэр, бохир усны тоолууржуулалтын бүрэн бүтэн байдал, баталгаажуулалтын байдалд үзлэг хийн хяналт тавих ажлыг 2025 оны 05 дугаар сарын 14-26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хяналт шалгалтад 9 аж ахуйн нэгжийн худгийн тоолуур, уурхайн шүүрлийн усны 6 тоолуурыг хамруулснаас дараах зөрчил дутагдал илэрч лац хөдөлгөсөн-1, лац суулгах-5, тоолуурын баталгаажуулалт хийгдээгүй-8, тоолуур эвдэрсэн-1 илэрсэн зөрчил дутагдлыг нэн яаралтай арилган ажиллах талаар заавар зөвлөмжийг өгсөн.</p> <p>2025 оны Дэлхийн усны өдрийг "Мөнх цэвдэг, мөсөн голоо хамгаалъя" уриалгатай тэмдэглэн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2, 5 дугаар сургуулийн ахлах ангийн 150 сурагчдад "Гүний ус, үнэ цэнэ, хамгаалал" сэдвээр танин мэдэхүйн сургалт хийж, "Усны хомсдол ба бохирдол" сэдэвт гар зургийн уралдаан, "Мөнх цэвдэг, мөсөн голоо хайрлая, хамгаалъя" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, "Усаа хэмнэе" сэдэвт "Тикток" бичлэгийн уралдаан, АШУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн оюутнуудын дунд уран илтгэлийн тэмцээнийг "Мөсөн голоо хамгаалъя" сэдэвтэйгээр хамтран зохион байгуулж нийт 1000 гаруй сурагч хамрагдаж усны талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн. Усны сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан "Худаг, уст цэг гаргах боломжтой газрын тодорхойлох геофизикийн багаж авах", "Цагаан цавын газрын доорх усны ордын нөөцийг шинэчлэх, дахин бордуулах, ажлын даалгавар төсөв тодорхойлох, зөвлөх үйлчилгээ авах ажил", "14 сумдын малчдын худагт түүвэр шинжилгээ хийх", "Усны тоо бүртгэлийн ажил зохион байгуулах" зэрэг ажлуудыг 3 дугаар улиралд багтаан хийгдэхээр төлөвлөсөн.</p>
--	--	--	--	----------------	--	--

124.	2	Хүн амын усан хангамжийн эх үүсвэрт цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	-	Төхөөрөмжийн тоо өссөн дүнгээр	-	28	<p>Айраг сумын Сайн ус багийн Дай булгийн усыг хуримтлуулах хөв цөөрөм, Даланжаргалан сумын Их амны сайрын үерийн усыг хуримтлуулах хөв цөөрөм, Өргөн сумын Сэвхүүлийн хөндийн хуурай сайрын үерийн усыг хуримтлуулах хөв цөөрөм, Эрдэнэ сумын Еншөөв багийн Бүлээний булгийн усыг хуримтлуулах хөв цөөрмийн зураг төсвийг "Эм Ти Эс Гидроинженеринг" ХХК байгаль хамгаалах сангийн 96.5 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгүүлсэн. Мөн агнуурын бүс нутгуудад 10 ширхэг хөв, усан сан байгуулах ажил эхэлсэн.</p> <p>Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 28.0 сая төгрөгийн хөрөнгөөр Мандах сумын 1 дүгээр багийн Элгэн, Улаанбадрах сумын Аргалын уул орчимд 2 хөв, Айраг сумын 2-р багийн "Дай уул" нэртэй газарт 2 тн-ний багтаамжтай 1 хөв байгуулах ажлыг "Тайшин шин юань"ХХК 4.0 сая төгрөгийн санхүүжилтээр, Даланжаргалан сумын Далантүрүү булгийн орчимд 5 тн-ний багтаамжтай 1 хөв байгуулах ажлыг "Сармай дээлт"ХХК 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр, Иххэт сумын Бүрдэнэ багийн "Зүүн цагаан дэл" нэртэй ангийн бүс нутагт 2-3 тн-ний багтаамжтай 1 хөв байгуулах ажлыг "Эрдэнэс кристалл менералс"ХХК 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр, Сайншанд сумын Хан баянзүрх уулын баруун талд 3 тн-ний багтаамжтай 1 ширхэг хөв байгуулах ажлыг "Салхин парк" ХХК 2.0 сая төгрөгийн санхүүжилтээр, Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн "Ханги нуур" нэртэй газарт 1 хөв байгуулах ажлыг "Маунтэйн хантинг" ХХК 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөж 7 сард багтаан ашиглалтад оруулахаар хүлээгдэж байна.</p>	70%
125.	3	Хөдөө аж ахуйн ус хангамжийн нөхцөлийг сайжруулж, нэмэгдүүлэх	-	Шинээр гаргасан худгийн тоо	-	14	<p>Бэлчээрт инженерийн хийцтэй-521, богино яндант-29, бетон хашлгат-534, энгийн уурхай-2190, нийт 3279 худгийг ашиглагдаж, бэлчээрийн 41.3% -ийг усжуулсан.</p>	70%

						<p>Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/43 дугаар тушаалаар улсын төсвийн 103,0 сая төгрөгийн санхүүжилтээр Өргөн, Улаанбадрах, Сайншанд суманд тус бүр 1, нийт 3 инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажлын гүйцэтгэгчээр “Эхний эхэн” ХХК шалгарч, гэрээ байгуулах шатандаа байна.</p> <p>Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 395,5 сая төгрөгийн санхүүжилтээр Айраг-3, Сайхандулаан-2, Хөвсгөл -1, Сайншанд -4, нийт 10 инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажлыг “Рашаан-Ундрах” ХХК, “Баясах ус эрдэнэ” ХХК, “Эхний эхэн” ХХК тус тус гүйцэтгэж, 40 гаруй хувьтай үргэлжилж байна.</p> <p>Хатанбулаг, Эрдэнэ сумд ОНХС-ийн 9,0 сая төгрөг, малчдын оролцооны 2 сая төгрөгийн хөрөнгөөр нийт 10 гар худгийг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэж, 60 гаруй хувьтай үргэлжилж байна.</p> <p>Бэлчээрт шинээр 13 инженерийн хийцтэй худгийг ашиглалтад оруулж, энгийн уурхайн 10 худгийг сэргээн засварласнаар 29,5 мянган га бэлчээрийг усжуулж, 35,3 мянган толгой мал услах боломж бүрдэх юм.</p> <p>Айраг сумын ОНХС-ийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр хөдөөгийн 4 багийн 5 байршил цэгт усны геофизикийн хайгуулын ажлыг “Далд эрдэнэ мөнх” ХХК гүйцэтгэж дууссан.</p>		
126.	4	“Хэрлэн тооно” төслийн бүсэд ногдох хэсгийг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-	Дэмжлэгийн тоо	2	4	<p>Хэрлэн тоонот, Орхон онги ус дамжуулах хоолойг барих төслийн ТЭЗҮ боловсруулах судалгааны багт тус аймагт 2 удаа ажиллаж, төслийн үйл ажиллагааг танилцуулсан. Аймгийн зүгээс ТЭЗҮ боловсруулахад шаардагдах судалгаа, мэдээллийг гарган өгч дэмжиж ажилласан. Мөн дээрх төслийн эхлэл болох Цагаан бургастай-Онгийн усан цогцолбор байгуулах улаан нуурын экосистемийг сэргээх төслийн нээлтэд аймгийн Засаг дарга оролцож, хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.</p>	50%

33.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

127.	1	Агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрүүдийг бууруулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Төслийн гүйцэтгэлийн хувь	50	100	<p>Агаарын чанарыг сайжруулах чиглэлээр аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Агаар, орчны чанарыг стандарт түвшинд хүргэж бохирдуулагчдын тоог 20 хувиар бууруулах зорилт тавьж Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Дорноговь аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/493, А/670 дугаар тушаал, захирамжаар Сайншанд, Замын-Үүд сумын “Агаарын чанарыг сайжруулах, бүс тогтоох, бүсэд мөрдөх журам”-ын дагуу агаарын чанарын бүсэд 2025 онд 10 ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний дагуу агаарын чанарын хяналт шинжилгээг 01-04 дүгээр саруудад өдөрт 3 удаа, 05 сард өдөрт 2 удаагийн давталтаар хэмжилтийг хийж нийт 302 удаа дээж авч азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хий (SO₂)-н шинжилгээг лабораторийн орчинд хийж, шинжилгээний дүн мэдээг ЦУОШГазрын Орчны хяналт шинжилгээ сайтад нийт 130 удаа дамжуулсан. Сайншанд хотын агаарын чанар үзүүлэлтээр хүхэрлэг хийн дундаж агууламж 0.009мг/м³, Азотын давхар ислийн дундаж агууламж 0.028 мг/м³ байгаа нь хүлцэх хэмжээнээс давсан тохиолдол ажиглагдаагүй.</p> <p>Монгол гэрийг дулаан, аюулгүй, эрүүл орчин болгох зорилготой ЧИП төслийг аймгийн хэмжээнд сурталчлах арга хэмжээ зохион байгуулан CHIP (Cooking, Heating and Insulation Products) нь: Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, агаар сэлгэлтийн систем, дулаан хадгалах бүрээс бүхий иж бүрэн шийдлийг танилцуулж төслийн хүрээнд Сайншанд сумын 10 айл, өрхөд CHIP багцыг хүлээлгэн өгснөөр нийт 56 тонн нүүрсний хэрэглээг бууруулсан.</p> <p>Мөн нарны гэрлийн энергийн цахилгаан энергид хувирган ахуйн цахилгааны хэрэглээгээрээ зуны цагт үнэ төлбөргүй,</p>	70%
------	---	--	---	---------------------------	----	-----	--	-----

							<p>халаалтын улиралд хямд үнээр ашиглах боломжийг 1000 айлд нэвтрүүлэхээр "Гүехэн далай" ХХК-тай хамтран төсөл хэрэгжүүлэх санамж бичгийг 2025 оны 05 дугаар сард байгуулан төслийн эхлэлийг тавьсан.</p> <p>"Инженерүүдийн шийдэл холбоо" ТББ-тай хамтран Сайншанд сумын иргэдэд Нарны цахилгаан үүсгүүрийн системийн төрлүүд, өөрийн хэрэглээнд тохирсон нарны цахилгаан үүсгүүрийн хэмжээ, үнэ, хамрагдах боломжтой ногоон зээлийн нөхцөлүүд, өөрийн байшинд нарны цахилгаан үүсгүүрийг суурилуулсан бодит жишээтэй танилцах зэрэг мэдээлэл, сургалтыг 06 дугаарын сарын 05-ны өдөр зохион байгуулж 25 иргэнийг хамруулж, мэдээлэл өгсөн дээрх төслүүдийн үр дүнд халаалтаа нарны цахилгаан үүсгүүрээр шийдвэрлэх иргэдийн хандлага нэмэгдсэн. Сайншанд сумын 8 дугаар багийн холбооны 4,5,6 дугаар гудамжаар бохир усны шугам татах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж, тендерийг 2025.06.24-д нээхээр хүлээгдэж байна. Энэхүү ажил хийгдсэнээр айл өрхүүд цэвэр, бохир усны нэгдсэн сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ.</p>	
128.	2	Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжих	-	Арга хэмжээний тоо	1	3	<p>"Некст электроник" Сайншанд цахилгаан барааны салбар дэлгүүрээс жил бүрийн 2-р улиралд хуучин цахилгаан хэрэгслээ авчирч худалдан хөнгөлөлтийн купон олгох аян өрнүүлж 7 тн цахилгаан барааны хог хаягдал цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.</p> <p>"Хоггүй Сайхандулаан", "Аюулыг авдарлая аян", "Нэг чихэр-нэг зай", "Холивол хог, ангилбал баялаг" зэрэг 4 нөлөөллийн аяныг өрнүүлэн 24,4 тн хуванцар хог хаягдлыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт тус тус нийлүүлж эргүүлэн татах менежментийг бүрдүүлсэн.</p> <p>Сайншанд суманд хог хаягдал дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Экоговь" үйлдвэрийг дэмжиж</p>	70%

							"Түншлэл ба хөгжил" бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрөөс 150,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор үйлдвэрийн ажлаа өргөжүүлж, барилгын агуулах, тоног төхөөрөмж татан авалтын хийгдэж байна.	
129.	3	Сайншанд, Замын-Үүд сумдын төвлөрсөн хогийн цэгт ландфилл технологийг нэвтрүүлэх	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	1	2	Сайншанд Тохижилт үйлчилгээний газрын 21,2 сая төгрөгийн хөрөнгөөр төв хогийн цэгийн 50х50 хэмжээтэй 3,5 метрийн гүнтэй нүхийг 4 машин техник, 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр нийт 26 өдөр булшлах ажлыг зохион байгуулсан. Замын-Үүд суманд 2023-2026 онд төвлөрсөн хогийн цэгийг цэгцлэх зорилгоор "Замын-Үүд сум, сэвхүүлийн тойром, сумын нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх" төслийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр нийт 4.0 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр "Элемент" ХХК-тай хамтран ажиллаж 70 га орчим талбайд тархсан хог хаягдлыг 10 га талбайд шахаж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, химийн гаралтай хог хаягдлыг стандартын дагуу устгах, барилга болон бусад төрлийн хог хаягдлыг ландфиллийн аргаар устгах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%
130.	4	Сайншанд сумын нутаг дахь Найрамдлын хур хогийг цэвэрлэх ажлыг эхлүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	50	Найрамдлын хур хогийг цэвэрлэхэд нийт шаардагдах 30 хоногт 34 машин техник, 270л түлш шатахууны нийт 89.2 сая төгрөгийн зардлын тооцоог гаргаж 3 дугаар улирал эхлүүлэхээр төлөвлөж байна.	ХБ
131.	5	Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж "Карбон кридет"-ийг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгааны цэг байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	70	100	Карбон кредитийг орон нутагт нэвтрүүлэх, судалгааны цэг байгуулах ажлын хүрээнд судалгааны ажил хийгдэж байна. Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг "Шамбала-2056 инженерийн суурийн" төсөл нь 2020-2024 оны хооронд нийт 66,857 мод тарьсан. Ургамжилтын нормчилсон индекс нь 0.3 буюу дунд зэргийн ургамалжилттай. Ургамлын масс 44,260,359 кг болсон байна. 4 жилийн	70%

							хугацаанд нийт карбон кредит /нүүрстөрөгч шингээлт/ 20,802,378 кг буюу 20,800 тонн шингээсэн тооцоолол байна. Тус төсөл нь байгаль орчин болон карбон кредитийн хувьд чанартай мэдээлэлд суурилсан үнэлгээ хийсэн байна. Модны тоо, ургамлын масс, нүүрстөрөгчийн шингээлт зэргийг тооцсоноор олон улсын зах зээлд гарах суурь болсон байна.	
132.	6	Хөрс бохирдуулагч нүхэн жорлонгийн тоог бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Бууруулсан нүхэн жорлонгийн тоо	20	100	Аймгийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа нүхэн жорлонгийн судалгааг 2 дугаар сард гаргасан. Судалгаагаар гэр хорооллын айл өрхийн хөрс бохирдуулагч 4570 нүхэн жорлон, малчин өрхийн 4421 нүхэн жорлон, төрийн байгууллагын 13 нүхэн жорлон, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид 57 нүхэн жорлон, худалдаа үйлчилгээний төв, захад 28 нүхэн жорлон, амралтын газар, жуулчны баазад 50 нүхэн жорлон, сум суурин, төв зам дагуух нийтийн эзэмшлийн зам талбайд 48 нүхэн жорлон, нийт 9187 нүхэн жорлон ашиглагдаж байгаа бөгөөд 2028 онд хүртэл 8316 болгож бууруулахаар төлөвлөлтийг гаргаж 2025 оны 01/360 дугаар албан бичгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлсэн. БОУАӨСайдын 2024 оны 07 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/909 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулж 03 дугаар сард Айраг, Даланжаргалан сумын 6 компанийн 8 ШТС-ын үйл ажиллагааг шалгаж стандартын шаардлага хангасан АЦБ-тай–1 ШТС, Засварын ажилтай-2 ШТС, үйл ажиллагаа зогссон-1 ШТС, захирамжийн хэрэгжилт хангаагүй-4 ШТС-ийг хамруулсан. Дээрх стандартын шаардлага хангаагүй Айраг сумын “Хишиг-Ойл” ХХК, Даланжаргалан сумын “М-ойл” ХХК-ийн 2 салбар, “Жаргалант-ойл” ХХК-д зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж ажилласан. Айраг, Сайншанд сумын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа улсын	70%

							<p>чанартай автозам дагуух 4 байршил дахь 6 нүхэн жорлон буулгаж, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд сумыг дамжин өнгөрөх 6 ариун цэрийн байгууламжид ариутгал халдваргүйтгэл хийж хөрсний бохирдлыг буурууллаа.</p> <p>Мөн гэр хороолол, албан байгууллага, амралтын газар, жуулчны баазуудын нүхэн жорлонг хөрсөнд нэвчилтгүй эко байгууламжаар солих, шинэчлэлийг “Ногоон зээл” -ийн үйлчилгээгээр шийдэх боломжийн талаар 3 төрлийн зөвлөмжийг аймгийн Байгаль орчны газар болон Эрүүл мэндийн газраас бэлтгэн цахим сүлжээгээр иргэдэд хүргэх зэрэг ажлуудыг зохион байгуулж албан даалгаврын биелэлт 30 хувьтай үргэлжилж байна.</p>	
34. Ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.								
133.	1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, аж ахуйн нэгж, иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх	-	Тарьсан модны тоо	100000	360000	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44 дүгээр “Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай” зарлигийн дагуу аймгийн хэмжээнд 5,6 дугаар саруудад мод тарих аяныг өрнүүлж 139 аж ахуй нэгж, байгууллагууд, 10000 гаруй сурагчид, иргэд, ажилтан, албан хаагчдын оролцоотойгоор нийт 8 төрлийн 53926 ширхэг мод, бут сөөгийг 12.47 га талбайд шинээр тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлж, Сайншанд сум “Говь парк” цэцэрлэгт хүрээлэн, “Далай шанд” цэцэрлэгт хүрээлэнгийн 4 га газарт 4900 ширхэг мод, Айраг суманд “Айраг төгөл” төслийг хэрэгжүүлэхээр 2 га газарт 1500 ширхэг мод, Өргөн сум 2 га, Иххэт сум 2 га, Эрдэнэ сум 1 га, Алтанширээ сум 0.01 га, Даланжаргалан сум босоо тэнхлэгийн А0102 авто зам дагуу 1,23 га ногоон байгууламжийн усан хангамжийг шийдэж 1 худаг гаргаж 3500 ширхэг мод, мөн Цомог багийн зэвсэгт хүчний 281 ангийн нийтийн эзэмшлийн талбайд 0,23 га газарт 3500 модыг тус тус тарьсан.</p> <p>“Миний мод-Бидний төгөл” төслийг Боловсролын газраас хэрэгжүүлж 14 сумын 21</p>	90%
				Шинээр нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ га	10	30		
				Модны ургалтын хувь	-	78		
				Ойжуулсан талбайн хэмжээ га	-	116903		
				Хамгаалалтын ойн зурвасын хэмжээ га	9	39		

							<p>сургуулийн суралцагч хашаандаа, малчны хотондоо болон төвлөрсөн байрны гадна талбайд нийт 7288 мод тарьж, зуны амралтаараа ургуулах даалгаврыг өгсөн.</p> <p>Байгаль орчин уур амьсгалын яамнаас санаачлан хэрэгжүүлж байгаа "Хашаандаа 5 мод тарья" аяны хүрээнд мод тарих аж ахуй нэгж, байгууллагуудтай гэрээг байгуулан аймгийн хэмжээнд 320 өрхийн хашаанд 1600 ширхэг тарьц, суулгацыг тарихаар бэлтгэл ажил хийгдэж байна. Өмнөх онд таригдсан модны ургалтын хувийг 5 сард тодорхойлох ажлыг хийхэд сумдын хэмжээнд нийт 108451 ширхэг тарьц, суулгац тарьснаас ургалтын хувь 76.9-тай байна. Өмнөх оны ургалтын хувьтай харьцуулахад 1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд байнгын үйл ажиллагаа явуулж байгаа 6 мод үржүүлгийн газрын 72 га талбайд үржүүлэг хийж 50,000 гаруй тарьц, суулгацыг хаврын тарилтад нийлүүлсэн. Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн 30 га талбай бүхий Агроэкологийн хүрээлэнгийн мод үржүүлгийн талбайн өвлийн хүлэмжинд гүйлс, харгана, хонхот харгана, хайлаас зэрэг 4 төрлийн 30000 ширхэг модыг бортогонд, сухайн 56000 ширхэг модлог мөчрийг гадаа талбайд тарьж нийт 5 төрлийн 86000 модыг үржүүлсэн. Мөн Сайншанд сумын 7 дугаар багийн нутаг "Далай шанд"-д гэх газарт "Энержи парагон" ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 10 га талбайд хамгаалалтын зурвас байгуулж, хашаажуулалт, худаг, усалгааны систем зэрэг иж бүрэн системтэй Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж, зурвасыг бий болгосон.</p>	
134.	2	Сайншанд, Замын-Үүд сумдад "Garden city" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	50	100	<p>"Garden city" төслийн хүрээнд Сайншанд сум төслийн хүрээнд нийтийн эзэмшлийн 6 байршил 35 км зам дагуу 350.0 мянган хайлаас, Шинээр 3 байршил цэцэрлэгт хүрээлэн байгуулж 6300 мод тарих төлөвлөлтийг гаргаж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн</p>	50%

							<p>батлуулсан байна. Энэ жил Сайншанд сумын хэмжээнд нийтийн эзэмшлийн газарт 7 төрлийн 8098 мод таригдаж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн.</p> <p>Замын-Үүд сумын Сүлд багт байрлах "Найрамдалт цэцэрлэгт хүрээлэн", "Гэр бүлийн талбай" , авто замын хамгаалалтын 5 байршил 2км газарт 10 төрлийн нийт 9112 ширхэг мод шинээр тарьж нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг 3.2 га талбайгаар нэмэгдүүлсэн. Мөн, иргэд, аж ахуй нэгж байгууллага, айл өрх, байгууллагын орчин тойронд болон хил хооронд 8 төрлийн 12,238 ширхэг модыг тарьж хашаан дахь ногоон байгууламжийг нэмэгдүүлснээр сумын хэмжээнд нийт 21,350 ширхэг модыг хаврын тарилтаар суулгасан байна.</p>	
135.	3	Ногоон байгууламжийн усалгааны систем байгуулах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	50	100	<p>Сайншанд сумын "Иргэдийн цэцэрлэгт хүрээлэн"-ийн 800 метр газарт 24,0 сая төгрөгийн хөрөнгөөр иж бүрэн дуслын усалгааны систем, мөн 7 дугаар багийн нутаг "Далай шанд"-д гэх газарт "Энержи парагон" ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 10 га талбайд хамгаалалтын зурвас байгуулж, хашаажуулалт, худаг, усалгааны систем зэрэг иж бүрэн системтэйгээр шийдэж ногоон байгууламж, хамгаалалтын зурвасыг бий болгосон. Даланжаргалан сум босоо тэнхлэгийн А0102 авто зам дагуу 1,23 га ногоон байгууламжийн усан хангамжийг шийдэж 1 худаг, Хатанбулаг шинээр нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн 0.7 га газарт усалгааны систем, Мандах "Мандах төгөл" цэцэрлэгт хүрээлэнг дуслын усны системийг суурилуулж усалгааг жигдрүүлсэн. Өргөн сум нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид 320метр хашаа, 200 метр усалгааны систем суурилуулах, Айраг сум Цагаандөрвөлж хайрханы энгэрт 2 га газарт худаг гаргаж, усжуулалтын систем суурилуулах, Эрдэнэ сум 2 га талбайд усалгааны системийг суурилуулахаар ажлыг</p>	70%

							<p>эхлүүлсэн.</p> <p>Замын-Үүд сумын "Борхойн баян бүрд" ОНӨ ААТҮГ нь ойн зурвас буюу 1 га газарт далан босгож, 2 худгийг шинээр гаргаж намираа усалгааны системтэй болсноор болсон байна. Дээрх ажлууд хийгдсэнээр 6 сумын хэмжээнд 12.03 га талбайд усалгааны системийг суурилуулж ногоон байгууламжийн байнгын усалгаатай болгосон байна.</p>	
136.	4	"Нэг тонн баялаг-Нэг мод" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	30	100	<p>"Нэг тонн баялаг-Нэг мод" хөтөлбөрийн төслийг боловсруулж ажлыг эхлүүлэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн А/618 дугаар "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын журмын 2.12. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн хүчин чадал, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрөл (алт, зэс, нүүрс болон бусад эрдэс түүхий эд олборлох, боловсруулах, уламжлалт ба уламжлалт бус газрын тос хайх, олборлох гэх мэт) үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллийн бүсийн хэмжээ, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний цар хүрээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах ажлын хэмжээнээсээ хамааруулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүний хэрэгжилтийг хариуцах нэгжтэй байна. Ойн тухай хуулийн 17.1 -т "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.1.1 ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих;" тус тус заалтуудыг үндэслэн болгон ажиллаж энэ онд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.</p>	50%
<p>35. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангана.</p>								

137.	1	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, санхүүжилтийг олгох, хяналт тавих, тайлагнах	-	Хэрэгжилтийн хувь	30	100	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр 18 төсөл, арга хэмжээ, он дамжин хэрэгжих 5 төсөл, арга хэмжээ, нийт 46.7 тэрбум төгрөгийн 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар 4 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2 ажлын гүйцэтгэлд 273,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	70%
138.	2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөж, АИТХ-аар батлуулах.	-	Бэлтгэж хүргэсэн мэдээллийн тоо	12	24	Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/172 тоот захирамжаар Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр 2026 онд хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний олон нийтийн хэлэлцүүлгийг 07 дугаар сарын 31-ний дотор зохион байгуулах ажлын хэсгийг баталсан.	50%
139.	3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн мэдээллийг onhs.mof.gov.mn системд оруулж, санхүүжилтийг олгох, хяналт тавих, тайлагнах	-	Цахим системд оруулсан сумдын мэдээллийн тоо	14	14	Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх нийт 11.8 тэрбум төгрөгийн 152 төсөл, арга хэмжээ батлагдсан. Тухайн онд худалдан авах ажиллагааг зохион байгуулах 82 төсөл, арга хэмжээнээс 65 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж 79.3 хувийн гүйцэтгэлтэй. Сумдын ОНХС-ийн гүйцэтгэлийн явцын мэдээг сар бүрийн 05-ны дотор Шилэн дансанд мэдээлж байна.	90%
140.	4	ОНХС-ийн үйл ажиллагааны 2023, 2024 оны хэрэгжилт 2025 оны төлөвлөлтийг УМС-ээр Жилийн гүйцэтгэлийн үнэлгээг үнэлэх	-	Цахим системд оруулсан сумдын мэдээллийн тоо	14	14	Удирдлага мэдээллийн системийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх хугацаа болоогүй	ХБ
36.Төрийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэхэд тогтмол хяналт тавина.								
141.	1	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлаг, сумдад явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлж, үр дүнг тооцох	ОНТ	Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	3 70	5 95	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 4 агентлаг, 14 суманд буюу нийт 18 байгууллагад явцын хяналт шинжилгээг хийж ажилласан. Явцын хяналт шинжилгээний дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагын удирдлагуудад уламжилсан.	70%

							Тайлант оны 09 дүгээр сард зөвлөмжийн үр дүнгээ тооцож гүйцэтгэлийн хяналт шинжилгээг хийхээр төлөвлөн ажлын удирдамжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар 2025 оны 05 сард батлуулсан.	
142.	2	Төрийн албан хаагчдыг хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээрх арга зүйгээр хангаж, мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх	4,0	Арга зүйгээр хангасан хүний тоо	100	200	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан ашиглах, тайлан бичих аргачлалыг давхардсан тоогоор 21 албан хаагчид хүргэж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Сумдын Засаг дарга нар өөрчлөгдсөнтэй холбогдуулан удирдлагуудад "Тайлан бичих арга зүй, анхаарах асуудал" сэдвээр 1 удаагийн сургалт зохион байгуулж, 14 сумын 40 гаруй албан хаагчид хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлангийн талаар болон ХШҮ-ний цахим сангийн хэрэглээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын 44 албан хаагчдад Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын талаарх мэдээлэл бэлтгэн хүргэж, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээрх арга зүйгээр хангасан.</p> <p>Тайлант оны эхний хагас жилийн байдлаар танхимын сургалтаар 84, ганцаарчилсан зөвлөгөөгөөр 21 нийт 105 албан хаагчдыг арга зүй, удирдлагаар ханган ажилласан.</p> <p>Сум, агентлагийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн батлахаар төслийг боловсруулан санал авч байна.</p> <p>Агентлаг сумдын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад холбогдох журмуудыг танилцуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан бичих арга зүй олгох сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	70%
143.	3	Албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэхээр ажлын гүйцэтгэлийг тогтмол дүгнүүлэх тогтолцоог бүрдүүлэх	ОНТ	Журам баталж хэрэгжилтийн хувь	0	70	Аймгийн Засаг даргын 2025 оны А/232 дугаар захирамжаар АЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, төрийн болон орон нутгийн бодлого, эрх бүхий албан	70%

							<p>тушаалтны шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ахлах мэргэжилтний албан тушаалыг шинээр бий болголоо.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг батлуулахаар төсөл боловсруулж байна. Мөн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхээр дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамж боловсруулан батлуулсан.</p>	
144.	4	Аймгийн гол үзүүлэлтийн нэгтгэсэн статистик ХШҮ-ний шалгуур үзүүлэлтийн сан бүрдүүлэх	-	ХШҮ-ний шалгуур үзүүлэлтийн тоо	0	50	Аймгийн гол үзүүлэлтийн нэгтгэсэн статистик хяналт-шинжилгээ, үнэлгээний 159 шалгуур үзүүлэлтийг боловсруулж, хэлтсүүдээс санал авах шатандаа явж байна.	70%
145.	5	Удирдлагын шийдвэр, байгууллагын дотоод дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх	-	ХШҮ-ний тоо Удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийг хянасан тоо	0 0	2 10	<p>Тайлант оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргаас баталсан захирамжлалын 406 баримт бичигт дотоодын хяналт шалгалтыг хийж, зөрчлийг арилгуулах арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>Мөн аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2020-2025 оны нийт 4586 захирамжийг нягтлан шалгаж, байнгын ажиллагаатай зөвлөл, хороо, ажлын хэсгүүдийг томилсон нийт 370 захирамжийг ялгаж цэгцлэн хариуцсан албан тушаалтнуудад жагсаалтаар хүлээлгэн өгч хяналтанд авхуулан ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд дотоодын хяналт, шалгалтыг хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Аймгийн Засаг дарга болон Засаг даргын орлогчийн ахлан ажиллаж байгаа байнгын ажиллагаатай 25 зөвлөл, хороо, дэд хороо, ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг өөрчлөн шинэчлэх эсэх хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж байна.</p>	90%

146.	6	Төрийн байгууллага болон албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд ХШҮ хийж, зөвлөмж хүргүүлэх	ОНТ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо Байгууллагын тоо	0 0	4 5	Аймгийн Засаг дарга болон аймгийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх, төрийн бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэхэд зорилгоор 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар ирүүлсэн 147 өргөдөл, гомдолд хяналт шинжилгээ хийсэн. Хяналт шинжилгээний дүнгээр өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, удирдах албан хаагчийн цохолтод заасан хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэсэн хариуг иргэнд мэдэгдээгүй, холбогдох байгууллагад шилжүүлсэн бол эргэж хяналт тавих, шилжүүлсэн талаар иргэнд мэдэгдээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн. Дээрх зөрчлийг арилгах цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад танилцуулан Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн. Мөн сумдын 2025 оны 01 дүгээр улирлын өргөдөл, гомдол хяналт шинжилгээ хийх талаар чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.	70%
37. Эх орноо хайрлан хамгаалах үзэл, бие бялдарын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлнэ.								
147.	1	Орон нутагт Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлах;	30 сая төгрөг	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж арга хэмжээ авсан байна	Төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан.	“Батлан хамгаалах тухай хууль”-ийн 17.1.1 дэх хэсэг хэрэгжинэ.	2025 он 03 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойг тэмдэглэн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд марш тусгай-бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн, “Зургаан баатар”-ын хөшөөт цогцолбор болон Монгол улсын баатар Данзанваанчигийн хөшөөнд цэцэг өргөх, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын зэвсэглэл техникийн үзэсгэлэн, хугацаат цэргийн алба хаагчдын нормын өдрийн хоолоор үйлчлэх нээлттэй хаалганы өдөрлөг, улс аймгийн алдар цолтой	90%

							<p>128, өсвөрийн 32 бөхийн барилдаан, Улсын цолтой бөхчүүдийн барилдааныг орон нутгийн телевизээр шууд дамжуулж, Зүүнбаян цэргийн хүрээний цэргийн ёслолын жагсаалыг Дорноговь аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах 10 байгууллагын 450 гаруй алба хаагчид оролцон зохион байгуулж, 1500 гаруй ард иргэд хамрагдсан.</p> <p>Мөн дээрх өдрүүдэд орон нутгийн DSB, DTV телевизүүдтэй хамтран “Цэргийн нэг өдөр” марш тактикийн тэмцээний тухай ойлголт, нэвтрүүлэг, арга хэмжээнүүдийн мэдээ, шторк, риилүүдийг бэлтгэн олон нийтэд түгээсэн.</p> <p>Жил бүр энэхүү үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн бөгөөд энэ жилийн хувьд орон нутгийн төсвөөс 29,884,660 төгрөгийг зарцуулсан.</p>	
148.	2	Цэргийн бэлтгэл үүрэгтний сургалт, “Оюутан Цэрэг” сургалт, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн сургалт, хугацаат цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, дайчилгааны нөөцийг нэмэгдүүлэх.	7 сая	Оюутан залуучуудад Цэргийн жинхэнэ албыг хаах боломжийг нээж, батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэнэ.	-	“Цэргийн албаны тухай хууль”-ийн 3.1.10, 7.7, 7.9 дэх заалт хэрэгжинэ.	<p>Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудад үндэслэн ОНТ 5,8 сая төгрөгөөр “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулалт явуулж, бүртгүүлсэн оюутнуудын мэдээллийг Батлан хамгаалах яамнаас хүлээн авч эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгалт авч, АШУИС-ын Дорноговь аймаг дахь салбар сургууль, Политехникийн коллежийн тэнцсэн 38 оюутны нэрсийг Батлан хамгаалах яаманд хүргүүлэн 2025 оны 04 сарын 26-аас 5 дугаар сарын 31-ийг дуустал АШУИС-ын Дорноговь аймаг дахь салбар сургуулийг түшиглэн 2 сарын хугацаанд “Цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Сургалтад хамрагдсан оюутнуудаас төгсөлтийн шалгалтыг зохион байгуулан тэнцсэн оюутнуудыг Зэвсэгт хүчний 336 дугаар ангид зохион байгуулагдах дараагийн шатны сургалтад хамруулна.</p>	90%
149.	3	Цэргийн насны иргэдийг эрүүлжүүлэлтийн ажлыг зохион байгуулах;	5 сая төгрөг	Хөдөлмөр эрхлэх, цэргийн	Төлөвлөгөөнд	“Цэргийн насны залуучууд	Аймгийн хэмжээнд 2025 оны I ээлжийн цэрэг татлагаас эрүүл мэндээр тэнцээгүй 187 өвчлөлттэй иргэнийг 2 дахь шатны эмнэлэгт	70%

				насны иргэдийг хамруулна.	тусгагдсан.	ын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх”	нарийн мэргэжлийн эмч нарын хяналтад авч эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулан 44,4 %-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Эрүүлжүүлэх төлөвлөгөөг гарган аймаг, сум багийн эрүүл мэндийн төвийн эмч нар хяналтад авч эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	
150.	4	Цэргийн албаны тухай хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд иргэдийг элсүүлэх, сургах;	-	“Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”	Монгол Улсын ЗГ-ын тогтоолоор хяналтын тоог тогтооно.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 80 дугаар тогтоол хэрэгжинэ.	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 70 иргэдтэй холбогдох хууль дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавин, бүртгэлийг хөтлөн ажиллаж байна. Аймгийн ИТХ-д цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаар, төсвийг батлуулахаа бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтын 08 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.	30%
151.	5	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах журмын хэрэгжилтийг хангах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавих, бүртгэл тооцоог хөтлөх;	-	Цэргийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, орон нутгийн төсвийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Хуульд тусгагдаж, Монгол Улсын ЗГ-ын 2016 оны 215 дугаар тогтоол.	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 215 тогтоолын хэрэгжилтийг хангана. Төсөв бүрдэнэ.	Засгийн газрын 2024 оны 95 дугаар тогтоол, аймгийн засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ний А/309 дүгээр захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 144 иргэний төлөх төлбөрийн суурь хэмжээг 14,2 сая тогтоосны дагуу 2025 оны 06 дугаар сарын байдлаар 45 иргэний 64,5 сая төгрөгийн төлбөр оногдуулсан.	70%
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ								72%